

МОДУЛЬ
9

СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛД
СУУРИЛСАН ХОХИРОГЧ/ДАВАН
ТУУЛАГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ



МОДУЛЬ 9

СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛД СУУРИЛСАН ХОХИРОГЧ/ ДАВАН ТУУЛАГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 улсад хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага юм. Монгол Улсад 1994 онд салбараа нээсэн ба Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурлыг бууруулах, Хүмүүнлэг, Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө ажиллаж байна.

Хүүхдийг Ивээх Сангийн захиалгаар боловсруулсан:

Амарсанаагийн Хонгорзул
Гантөмөрийн Түвшинжаргал
Пүрэвийн Энхчимэг

Хянан тохиолдуулсан: Энхбатын Цолмон
Энхболдын Жаргал
Баяндалайн Баярмаа
Нямсүрэнгийн Онон

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Хорлоогийн Балдандорж

Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлж буй НҮБ-ын “Итгэлцлийн Сан”-гийн санхүүжилттэй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд боловсруулж, хэвлүүлэв.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 | Цахим шуудан: Mongolia.secretary@savethechildren.org | Модулийг цахим хэлбэрээр www.savethechildren.mn вэб хуудаснаас авах боломжтой.

Улаанбаатар хот, Монгол Улс 2023 он

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.	7
НЭГ. БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ/ДАВАН ТУУЛАГЧ ХҮҮХДИЙН СЭТГЭЛЗҮЙ, СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛ, ШИНЖ ТЭМДЭГ, ҮР ДАГАВАР.	8
1.1. Сэтгэцийн гэмтэл гэж юу вэ, төрөл болон комплекс сэтгэцийн гэмтэл	9
1.2. Сэтгэцийн гэмтлийн шинж тэмдэг ба нөлөө	18
1.3. Сэтгэцийн гэмтэлд дахин өртөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах нь	23
ХОЁР: СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛД СУУРИЛСАН ХОХИРОГЧ/ДАВАН ТУУЛАГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ БА ТОГТОЛЦОО	27
2.1. Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим.	28
2.2. Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээний онол, арга зүй	31
2.3. Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээний тогтолцоо, хэрэгжүүлэх механизм ба сайн туршлага	47
НОМ ЗҮЙ.	54

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхдийн эрхийг хүндэтгэн хангах, хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, олон улсын, бие даасан, хараат бус иргэний нийгмийн байгууллага юм. ХИС-гийн Хүүхэд хамгааллын хөтөлбөр нь НҮБ-ын Итгэлцлийн Сан (UN Trust Fund)-гийн санхүүжилтээр “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийг гурван жилийн (2021-2024) хугацаатай, нийслэлийн Баянгол, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт хэрэгжүүлж байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, НҮБ-ын хороодын дүгнэлт зөвлөмжүүдэд охин хүүхдийг бэлгийн болон бусад төрлийн мөлжлөгөөс хамгаалж, хүчирхийллийн аливаа хэлбэрээс охидыг хамгаалах, нэр төрийг нь хүндэтгэхийг эрхэмлэх ёстойг онцлон тэмдэглэдэг. Монгол Улсад хүчирхийлэлтэй тэмцэхэд тодорхой ахиц, өөрчлөлт гарч байгаа хэдий ч жендэрт суурилсан хүчирхийлэл, охидын эсрэг хүчирхийллийн тоо буурахгүй хэвээр байгаад зовниж, Хүүхдийг Ивээх Сан охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах зорилго тавин ажиллаж байна.

Төслийн хүрээнд бид хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг нэвтрүүлэх зорилго бүхий 11 модулиас бүрдэх багц гарын авлагыг боловсруулан та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна.

Тус гарын авлага нь хүүхэд хамгааллын салбарын мэргэжилтнүүдийн хүүхэд хамгааллын тогтолцоо, салбарын ажилтнуудын оролцоо, үүрэг, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх үндсэн ойлголт, сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй (хохирогч/даван туулагчид ээлтэй) арга зүй, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн анхан шатны тусламж үйлчилгээ, гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын хариу арга хэмжээ, кейс менежмент, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон охидод үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ, хүүхэд хамгааллын ажилтнуудын ажлаас халшрах хам шинжийн талаарх ойлголтыг өгч, хүүхдэд сэтгэцийн дам гэмтэл учруулахгүйгээр, цаг алдахгүй мэргэжлийн үйлчилгээг чанартай үзүүлэх үр чадварыг өсгөх зорилготой юм.

Олны хүч оломгүй далай гэдэг ээ.

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох, эрхээ ялгаварлалгүй эдэлдэг, хариуцлагатай нийгмийг цогцлоох үйлст хувь нэмрээ оруулж, сургалтын энэхүү багцын “Модуль 9. Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/ даван туулагч төвтэй арга зүй” хэсэгт гэрээлэн ажилласан эрдэмтэн, судлаач Амарсанаагийн Хонгорзул, Гантөмөрийн Түвшинжаргал, Пүрэвийн Энхчимэг болон Хүүхдийг Ивээх Сангийн төслийн багтаа талархал илэрхийлье.

Энэ чиглэлээр бидний нэгэн адил хувь нэмэр оруулж, Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж байгаа зорилго нэгт, хөгжлийн болон хүмүүнлэгийн бүх түншүүддээ талархал илэрхийлье.

Энхбатын Цолмон

ХИС-гийн Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрүүдийн менежер

Багц гарын авлагын 11 модуль тус бүрийн хоорондын уялдаа холбоо, зорилгыг доорх хүснэгтэд харууллаа.

Модулийн нэр	Зорилго
Модуль 1 Хүүхдийн эрх, хамгаалал ба хүүхэд хамгааллын бодлого	Хүүхдийн эрх, эрхэд суурилсан хандлага, хүүхдийн хамгаалагдах эрх, хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга зам, бодлогын талаар онол, практик хэрэглээ, сайн туршлагыг танилцуулах
Модуль 2 Хүүхэд хамгааллын үйлчилгээ ба кейс менежмент	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх гэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин тус бүрд хамгааллын үйлчилгээ хүргэх, тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээг хэрхэн хүргэх
Модуль 3 Хүчирхийлэлд өртсөн хүүхэд үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байрны үйлчилгээ	Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байранд байрлаж буй хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нас, сэтгэцийн онцлогт тохирсон үйлчилгээг хэрхэн үзүүлэх, үйлчилгээг стандартын дагуу сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй байдлаар үзүүлэхэд анхаарах асуудал, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдэд анхан шатны болон хариу үйлчилгээг хэрхэн үзүүлэх
Модуль 4 Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ	Асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ, үйлчилгээнд хамруулах хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлын үнэлгээний талаар үндсэн ойлголттой болж, хувилбарт үйлчилгээнд хамрагдах шаардлагатай хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээний төлөвлөлт хийхэд баримтлах зарчим, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг танилцуулах
Модуль 5 Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхэгжүүлэх, амьдрах ухааны ур чадвар олгох	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн давуу талд тулгуурлан хүүхэд хамгааллын үйлчилгээ, тэр дундаа нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх талаар арга зүйн үндсэн ойлголт, онолын үндэслэлийн талаар мэдлэг нэмэгдүүлэх, мөн хүчирхэг болгох амьдрах ухааны ур чадварыг олгох нийгмийн ажлын арга зүй, хандлага зэрэг талаар мэдээлэл өгөх
Модуль 6 Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал	Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал, хүүхдэд тохиолдох эрсдэл, үйлчилгээний зохион байгуулалт, удирдлага, кейс менежмент, урьдчилан сэргийлэлтийн талаар ойлголт өгөх.
Модуль 7 Хүн худалдаалах гэмт хэрэг ба жендэрт суурилсан хүчирхийлэл	Жендэрийн үндсэн ойлголт, түүний эрх зүйн зохицуулалт, үндэсний тогтолцоо, жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний төрөл хэлбэр, хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт, энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчийг илрүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаар мэдлэг нэмэгдүүлэх

Модуль 8

Хүүхэд худалдаалах гэмт хэрэг-илрүүлэлтийн стратеги болон үйл явц

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин, зохицуулалтын онцлог, хүүхдийг худалдаалж буй төрөл, хэлбэр, хохирогч хүүхдийг илрүүлэх, таньж мэдэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулах талаар нэгдсэн ойлголт өгөх.

Модуль 9

Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагч төвтэй арга зүй

Сэтгэцийн гэмтлийн тухай ерөнхий ойлголт, төрөл, илрэх нийтлэг шинж тэмдэг, сэтгэцийн гэмтэл бие махбод, оюун санаа, сэтгэл хөдлөл, нийгмийн харилцаанд нөлөөлөх сөрөг нөлөө, дахин сэтгэцийн гэмтэлд урчлуулахаас урьдчилан сэргийлэхэд анхаарах зүйлс, сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний зарчмуудын талаар ойлголт өгөх

Модуль 10

Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх, өөрсдийгөө хамгаалах нь

Ажлын байрны стресс, ажлаас халшрах хам шинжийн ойлголт, үүсэх үе шат, нөлөөлөх хүчин зүйл тухай мэдлэг олгоно. Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжид өртөх шалтгаан, илрэх сөрөг үр дагавар, урьдчилан сэргийлэх сэтгэл зүйн бэлтгэх, ажлаас халшрах хам шинжийг үнэлэх аргачлал, түүнийг даван туулах сэтгэл зүйн заслын тусламжид суралцах болно.

Модуль 11

Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч/даван туулагчдад үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй шинжүүд, хохирогч/даван туулагчдад илрэх сэтгэл зүйн болон бие махбодын шинжүүдийг ялган таньж мэдэх, сэтгэцийн гэмтлийн тухай ойлголт, төрөл, нөлөөлөх хүчин зүйлс, хүчтэй стресст өгөх цочмог хариу урвалын тухай ерөнхий ойлголт, гэмтлийн дараах стрессийн эмгэг, түүнд хэрэглэх сэтгэл зүйн зөвлөгөөний арга техникүүдийн талаар анхан шатны мэдээлэл өгөх.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГДСЭ	Гэмтлийн дараах стресст эмгэг буюу PTSD
ДОХ	Дархлал олдмолын хомсдол
ДСЭМҮЗ	Донтолт болон сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний захиргаа
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ХЭҮТ	Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв
SAMHSA	Substance Abuse Mental Health Service Administration

НЭГ

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ/ДАВАН ТУУЛАГЧ ХҮҮХДИЙН СЭТГЭЛЗҮЙ, СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛ, ШИНЖ ТЭМДЭГ, ҮР ДАГАВАР

- 1.1 Сэтгэцийн гэмтэл гэж юу вэ, төрөл болон комплекс сэтгэцийн гэмтэл
- 1.2 Сэтгэцийн гэмтлийн шинж тэмдэг ба нөлөө
- 1.3 Сэтгэцийн гэмтэлд дахин өртөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах нь

1.1

СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛ ГЭЖ ЮУ ВЭ, ТӨРӨЛ БОЛОН КОМПЛЕКС СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛ

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийг “даван туулагч” эсвэл “хохилогч” гэж нэрийдэх талаар салбарын эрдэмтэд, хүний эрхийн активистууд өнөөг хүртэл мэтгэлцэж байна. Судлаач Данн (2005) хүчирхийлэлд өртсөн хүнийг “хохилогч” гэж нэрлэснээр аргагүй байдалд орсон, гарцгүй, тусламж авч чадаагүй, сул дорой, идэвхгүй гэдэг санааг илтгэдэг бол эсрэгээрээ “даван туулагч” гэх нь сонголт хийж байгааг өөрөөр хэлбэл эерэг чанарууд, хүчирхийллийг даван туулах хүч, илаарьших зэрэг агуулгыг илтгэдэг хэмээжээ. Нэг талаараа “хохилогч” гэдэг нэршил “гэм зэмгүй” гэдэг утгатай учраас бодит байдлыг онож илтгэж байгаа ч нөгөө талаараа “хохилогч” гэдэг бас “сул дорой, эмзэг, өөрийнхөө төлөө үйлдэл хийх чадал дутмаг” гэдэг утга агуулж байдаг (Томпсон, 2000). Энэ утгаараа “хохилогч” гэх үг нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн (хүчирхийлэлд өртсөн нийт хохилогчдын 98% нь охид, эмэгтэйчүүд байдаг) өөрийн үнэлэмж, өөрийгөө тодорхойлоход сөргөөр нөлөөлөх талтай юм. Учир нь гэр бүлийн хүчирхийлэлд байсан ихэнх эмэгтэйчүүд хохилогч гэхээс илүү өөрсдийгөө «даван туулагч» гэж тодорхойлох хүсэлтэй байдаг талаар олон судалгаанд дурджээ. Жишээлбэл, Маккартигийн (1986) судалгаанд өөрийгөө “хохилогч” гэж тодорхойлсон эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийллийг өөрийнх нь амьдралыг “шийдсэн”, өөрийн үнэлэмжийг нь удирдан чиглүүлж, ноёлох үйл явдал гэж үзэж байжээ. Харин “даван туулагч” гэдэг нэршил хүчирхийллээс үүдсэн шархыг илаарьшуулах, эргэн сэргэх, тэсвэр тэвчээр гэсэнтэй утга нийцдэг (Томпсон, 2000). Зарим тохиолдолд шүүхийн үйл ажиллагаанд “хохилогч” гэдэг нэршил нь үйлчлүүлэгчийн гэм зэмгүй, хүч дорой байдлыг илтгэж байгаагаараа оновчтой. Харин сэтгэл зүйн хувьд илаарьших, даван туулах, өөрийн үнэлэмжээ эергээр шинээр тодорхойлоход “даван туулагч” гэх нэр томъёог ашиглах нь зүйтэй гэж (Келли, 1988) санал болгосон байдаг. Патертсон, Кампбелл (2010) нарын судалгаагаар илүү чадавхажсан, өөрийгөө “даван туулагч” гэж мэдэрсэн үйлчлүүлэгчид хүчингийн хэргийг хууль, шүүхэд мэдүүлж, шийдүүлэх хандлагатай байдаг аж. Даван туулагч гэдэг нь өөрийгөө хүчирхийлэлтэй харилцаанаас гарсан, хүчирхийллийн харилцаагаа даван туулж байгаа, илаарьших үйл явц эхэлсэн гэж үзэх хүмүүсийг хэлнэ.

Сэтгэцийн гэмтэл нь дараах шалтгааны улмаас үүсэж болно.

- Бэлгийн болон бие махбодын хүчирхийлэл (хүн хоорондын гэмт хэргийн бусад тохиолдол)
- Гэр бүлийн хүчирхийлэл (бие махбод, сэтгэл санаа, нийгэм, эдийн засаг)
- Хүүхэд насны хүчирхийлэл, хагацал
- Дам сэтгэцийн гэмтэл буюу хоёрдогч сэтгэцийн гэмтэл
- Эмнэлгийн хүнд оношилгоо
- Амь насны эрсдэл бүхий осол гэмтэл
- Дайн самуун
- Байгалийн гамшиг
- Гэнэтийн хагацал

Дээрх нийтлэг шалтгаанууд нь тухайн хүний онцлог, даван туулах чадвар, амьдралын туршлагаас шалтгаалан сэтгэцийн гэмтлүүдийг үүсгэх боломжтой.

Гэмтэл гэдэг нь бие махбодын шарх эсвэл сэтгэл зүйн хүчтэй цочрол бөгөөд олон талт хортой үр нөлөөг үзүүлдэг. Траума (Trauma) нь шарх гэдэг Грек үгнээс гаралтай үг.

СЭТГЭЦИЙН ГЭМТЛИЙН ТӨРЛҮҮД		
Цочмог хурц буюу нэг удаа болоод өнгөрсөн үйл явдлаас үүдэх	Архаг ужиг буюу олон удаагийн давтагдсан үйл явдлаас үүдэх	Комплекс буюу архаг ужиг гэмтэл
Авто машины осолд орох, хулгай дээрэмд өртөх, бие махбод болон сэтгэл санааны байдалд аюул заналхийлсэн байдалд өртөх, түүнийг гэрчлэх гэх мэт. Үйл явдлаас хойш нэг сар хүртэлх хугацаанд илэрч болно.	Тодорхой хугацаанд дайн тулаан, гэр бүлийн хүчирхийлэл, архаг хууч өвчин, эрүүл мэндийн ноцтой ажилбар, орон гэргүй байх, хүчирхийлэлтэй харилцаанд байх гэх мэт.	Ихэнхдээ итгэл даасан, асран хамгаалдаг байсан хэн нэгний зүгээс давтагдсан даамжирсан хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, бие болон сэтгэл санааны хүчирхийлэлд амьдрах, эрүүл мэндийн ноцтой гэмтэл, эмчилгээний үйл явцаас үүсэх сэтгэцийн гэмтэл, хүний наймааны хохирогч болох гэх мэт.

Цаашид энэхүү гарын авлагаар бид **Комплекс сэтгэцийн гэмтлийг** тусгайлан үзэх болно. Учир нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь хохирогч/даван туулагчийн нас, бие бялдрын хөгжил, бие даан шийдвэр гаргах чадамжгүй байдал, эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан үйлдэгддэг. Энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж буй хүн өөрийн эрх мэдэл, хүч чадал, давуу байдлаа ашиглан хүүхдийн итгэл, хүндлэл, биеэ хамгаалах чадваргүй, цайлган, сониучхан зэрэг нас, сэтгэхүйн онцлог байдлыг тэдний эсрэг урвуулах байдлаар үйлддэг.

Бэлгийн хүчирхийлэл аль ч насны хүүхдэд, ямар ч соёл, нийгмийн анги давхаргаас үл хамааран тохиолдож болно. Бэлгийн хүчирхийллийн хор уршиг нь хувь хүний:

- Сэтгэл хөдлөл
- Танин мэдэхүй
- Бие махбодын эрүүл мэнд
- Сэтгэлзүй болон итгэл үнэмшил
- Нийгмийн харилцаа болох өөртэйгөө харилцах харилцаанд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлж байдаг ба өргөн хүрээгээр улс орны нийгэм-эдийн засгийн хөгжилд нөлөөлж байдаг.

Манай улсын хувьд сүүлийн 3 жилд 18 хүртэлх насны хүн бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон 713 тохиолдол цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байдаг. Харин 2021 оны эхний 8 сарын байдлаар 228 хүүхэд бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт өртөж хохирсон байна. Жилд дунджаар 400-500 орчим хүчингийн хэрэг үйлдэгддэг ба тэдгээрийн 50-60 хувьд нь насанд хүрээгүй хүүхдүүд гэмтэж, бэртэж бие махбод болон сэтгэл санаагаар хохирсон байдаг (Цагдаагийн Ерөнхий Газар, 2020 он).

Сэтгэцийн гэмтлийн шалтгаант стрессийн талаарх ойлголт сүүлийн 40-өөд жилд яригдах болсон. Сэтгэцийн гэмтлийг ялган оношлоход хурцадмал маргаан үүсэж байсан ба эцэст Сэтгэцийн Эмгэг Оношилгооны Статистик Гарын Авлага (DSM 5)-д (2013) онд Сэтгэцийн гэмтэл ба Стрессийн шалтгаант өвчнүүд (Trauma and Stress Related disorder) гэдэг категори нэмэгдэж

орсон. Гэмтэл өгөхүйц үйл явц нь тухайн хүүхэд эсвэл насанд хүрэгчийн амьдралын талаарх суурь үзэл, итгэл үнэмшилд нь нөлөөлж гэр бүл, нийгэм орчинтойгоо тогтвортой бөгөөд итгэлтэй харилцаа үүсгэх чадвараа алдахад хүргэдэг. Ноцтой аюул, заналхийллийн эсрэг хариу үйлдэл үзүүлэх чадваргүй болсон үед сэтгэцийн гэмтэл нь хүний сэтгэц, бие махбодын болон мэдрэлийн системийн тогтвортой хэвийн ажиллагааг алдагдуулдаг.

“Сэтгэцийн гэмтлийн үйл явдлууд нь хүний дасан зохицох чадварыг дарангуйлдаг”.

Гэмтлийн талаарх орчин үеийн ойлголтын анхдагч судлаач
Жудит Херман

Жишээ төсөөлцгөө.


Та өөрийгөө 6 настайгаар төсөөлөөрэй. Орой болж унтахаар хэвтлээ. Гэнэт ээж, аавыгаа бие бие рүүгээ хашхирч байгаа хоолойг та сонсох болно. Бие тань чангарч, гэдэс чинь эвгүйрхэж байна. Таны дүү, эгч хоёр чинь ч бас сонссон болохоор бүгд орноосоо босож өрөөнийхөө хаалганы завсраар шагайн харав. Аав нь ээжийнх нь гарыг хөдөлгөхгүй барьчихсан, ээж чинь гараас нь мулттрааар тэмцэж байгааг харах болно. Ээж нь үйлж, хашхичин хавханд орсон амьтан мэт тэмцэнэ. **Үүнийг хараад нүүр чинь халуу шатан бүх бие халуу оргиж эхэлнэ.** Ээж чинь аавын чинь гараас мултраад гал тогоо руугаа орон аяга тавгуудаа хагачиж эхлэхийг сонсоод та тэдэн рүү “болиоч” гэж хашхиравч таныг сонсохгүй. Дүү чинь нуугдана, эгч чинь ээжийгээ хамгаалахыг оролдох боловч тэд та нарыг сонсохгүй. **Зүрх чинь улам хүчтэй цохилж, бие тань салгалан чичирч байна. Тэднийг зогсоохын тулд хамаг чадлаараа хашхиран уйлах болно.**

Энэ үйл явдал болоод өнгөрсний дараа хэдий тодорхой хугацаа өнгөрсөн ч дараагийн өөр нөхцөлд ээж, аавын тань дууны өнгө өндөрсөх төдийд нүүр чинь халуу шатан бүх бие халуу оргиж, зүрхний цохилт нэмэгдэн гар, хөл чинь салгалж болно.

Дээрх төсөөллийн жишээгээр бид хүчирхийлэл нь сэтгэц болон бие махбодын мэдрэлийн системд хэрхэн нөлөөлдөг болохыг төсөөлөн ойлгож болно. Гэмтлийн мэдрэл (Traumatic neurosis) гэх ойлголтыг Германы мэдрэлийн эмч Херман Оффенхайм (1858-1919) анх гэмтлийн дараах сэтгэцийн эмгэгүүд нь тархины органик (молекулын) өөрчлөлтөөс үүдэлтэй болохыг баталж энэхүү нэр томъёог нэвтрүүлж өдгөө нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн онол болон ашиглагдаж байна.

Сэтгэцийн гэмтлийг илүү нарийн ойлгож, сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээ, аргачлалыг хэрэглэж сурахын тулд бид бие махбод болон тархи мэдрэлийн тогтолцооны талаар анхан шатны ойлголттой болох хэрэгтэй.


Сэтгэцийн гэмтлийн дараа тухайн хүний хорвоо ертөнцийг харах өнцөг өөрчлөгддөг ба үүнээс шалтгаалан мэдрэлийн системд шилжилт, өөрчлөлт бий болно. Хохирогч/даван туулагчийн эрч хүч нь тэдний өдөр тутмын амьдралд хар аяндаа хүчтэй нөлөөлж, сэтгэлийн дотоод эмх замбараагүй байдлаа зохицуулахад чиглэдэг. Хүн аливаа зүйлийг тэвчих үед түүнд хүчтэй мэдрэгдэх бие физиологийн



урвалаа хянах, зохицуулах оролдлого нь архаг ядаргаа, фибромиалгиа буюу тодорхой бус биеийн зовуурт өвдөлтүүд болон бусад автоиммуний өвчлөл зэрэг олон төрлийн өвчний шинж тэмдгүүдийг бий болгодог. Үүнээс улбаалан сэтгэцийн гэмтлийн эмчилгээ нь бүхий л бие махбод, оюун ухаан, сэтгэл, тархийг цогцоор нь анхааран авч үзэх нь яагаад чухал болохыг харуулж байна.

Тархинд аюул өртсөнийг илтгэх дохиоллын систем асахад тархины хамгийн эртний хэсгүүд болох тархины ёзоорын хэсэг урьдчилан ажиллахаар программчлагдсан байдаг бөгөөд бие махбодын зугтах төлөвлөгөөг автоматаар идэвхжүүлдэг. Бусад хөхтөн амьтны нэгэн адилаар бидний тархины үндсэн бүтцийг бүрдүүлдэг мэдрэлийн эсүүд болон химийн нэгдлүүд нь бие махбодтой шууд холбоотой байдаг. Хуучин тархи удирдаж эхлэхэд дээд тархи болох ухамсарт оюун ухааныг хэсэгчлэн хааж биеийг гүйх, нуугдах, тулалдах, заримдаа хөлдөхөд буюу хөдлөх чадваргүй болоход хүргэдэг. Бид нөхцөл байдлыг бүрэн ухамсарлах үед бие махбод ухамсартайгаар хөдөлж магадгүй юм. Дайтах-тэмцэх, дайжих-зугтах, дагжих-гөлрөх, долигонох-бялдүүчлах хариу үйлдэл амжилттай болж аюулаас зугтаж чадвал бид дотоод тэнцвэрээ сэргээж аажмаар “ухаан” орох буюу анзаарч эхэлдэг. Хуучин гэх анхдагч тархи болон ухамсарт гэж нэрлэх тархины талаарх ерөнхий ойлголтыг дэлгэрүүлэн хүргэе.

Нэн түрүүн бидний тархины хамгийн чухал үүрэг нь ямар нэгэн хүнд хэцүү нөхцөлөөс амьд үлдэх явдал юм. Энэ үүргийг гүйцэтгэхийн тулд тархи нь дараах үйлдлүүдийг хийдэг:



Учир нь хүн төрөлхтөн хөхтөн амьтны бүлэг учраас бүлгээрээ амьд үлдэж, хөгжиж чаддаг ба эдгээр хэрэгцээ шаардлага, зохицуулалтад бие болон тархины хамтын ажиллагаа шаардагддаг. Эхийн хэвлийд хүүхдийн тархи үе шаттайгаар, доороос дээш чиглэлтэйгээр урган хөгжиж байдаг.

Хамгийн анхдагч хэсэг буюу төрөх үед ажиллаж эхэлсэн хэсэг бол үүнийг эртний амьтадын буюу мөлхөгчийн тархи гэж нэрлэдэг. Энэ нь тархины ишний хэсэгт нугасны гавлын яс руу орох хэсгээс дээд талд байрлана. Мөлхөгчийн тархи нь шинэ төрсөн хүүхдийн бүх хийж чадах зүйлийг буюу идэх, унтах, сэрэх, уйлах, амьсгалах, өлсөх, норох, тавгүй байдал мэдрэх, өвдөх, биеийн хэм мэдрэх, бие засах замаар биеэс хорт бодисоо гадагшлуулах зэргийг зохицуулах үүрэгтэй. Мөлхөгчийн тархины яг дээд талд лимбийн систем (limbic system) байдаг. Үүнийг

зарим эрдэмтэд өөрсдийн бүтээлдээ сэтгэл хөдлөлийн тархи ч гэж нэрлэсэн байдаг. Энэ тархийг хөхтөн амьтны тархи гэж нэрлэдэг. Учир нь бүлгээрээ амьдардаг, үр зулзагаа тэжээдэг бүх амьтад нэг тархитай байдаг. Хүн төрөлхтөн хөхтөн амьтны бүлэг учраас бүлгээрээ амьдарч, хөгжиж чаддаг ба эдгээр хэрэгцээ шаардлагадаа зохицуулалт, хамтын ажиллагааг шаарддаг. Тархины энэ хэсгийн хөгжил хүүхэд төрсний дараах үеэс хөгждөг.

Тухайн нөхцөлийг даван туулж амьд үлдэхийн тулд юу чухал, чухал биш вэ гэдгийг ялгах ба нийгмийн амьдралын аливаа сорилтуудыг даван туулахад туслах төв цэг юм. Сэтгэл хөдлөлийн тархи нь төв мэдрэлийн системийн гол цөм бөгөөд гол үүрэг нь хүний сайн сайхны төлөө анхаарал тавих явдал юм. Хэрэв аюул эсвэл онцгой ямар нэг боломж байгааг олж мэдвэл тодорхой даавруудыг ялгаруулан биднийг аюулаас сэрэмжлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Өөрөөр хэлбэл тархи нь тулалдах-зугтах (fight or flight) хариу үйлдлээр урьдчилан программчлагдсан зугтах төлөвлөгөөгөө ажиллуулдаг. Үүний үр дүнд дотоод эрхтэн системд мэдрэмжүүд төрж (цээж давчдахаас эхлээд салгалах, чичрэх, хурдтай болох гэх мэт) тухайн нөхцөлд оюун санааны анхаарал төвлөрч буй бүх зүйлд түр зуур зогсонги байдалд орж бие махбодын болон оюун санааны хувьд тухайн аюулд хариу үзүүлэхэд зөвхөн төвлөрч эхэлдэг. Эдгээр булчингийн болон физиологийн хариу урвалууд нь автомат бөгөөд бидний зүгээс ямар ч урьдчилсан төлөвлөгөө, бодолгүйгээр хийгдэх ба аюултай үйл явдал дууссаны дараа ухамсарт тархи (ухаалаг тархи – prefrontal cortex) хариу үйлдэл үзүүлж эхэлдэг. Ухамсарт тархи бол бидний гадаад ертөнцтэй холбоотой хүмүүс, юмс хэрхэн ажилладгийг ойлгох, зорилгодоо хэрхэн хүрэх, цаг хугацаагаа удирдах, аливаа үйлдлийн дарааллаа эрэмбэлэх гэх мэт ажиллагааг зохицуулах үүрэгтэй тархи юм.

Бие махбод болон оюун санааны хувьд нөлөөлж буй эдгээр мэдрэмжүүд бидний амьдралынхаа турш гаргадаг том, жижиг шийдвэрүүдэд маш их нөлөө үзүүлж байдаг. Жишээ нь: юу идэх, хаана унтах, хэнтэйгээ унтах, ямар хөгжимд дуртай байх, хэнтэй найзлах, хэнийг жигших гэх мэт (Trauma Conference, 2020). Тэгвэл сэтгэцийн гэмтэл нь тухайн хүний амьдралын туршид тархины лимбийн системийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулдаг.

Тиймээс тухайн хүн сэтгэцийн гэмтлийг насан туршдаа даван туулах шаардлагатай болдог гэж үздэг. Гэхдээ таагүй үйл явдал болгон **сэтгэцийн гэмтэл үүсгэхгүй** бөгөөд ижил үйл явдал нэг хүнд **сэтгэцийн гэмтэл учруулж болох боловч өөр хэн нэгэнд хүнд санагдахгүй байж болох** юм. Судлаачид тухайн үйл явдлын туршлага (гэмтлийн шинжтэй эсэх) нь хүн бүрд харилцан адилгүй байх тул **“гэмтэл үүсгэж болзошгүй үйл явдал”** гэсэн нэр томъёог ашигладаг (Trauma Conference, 2020). Жишээлбэл: Гэр бүлийн хүчирхийлэлтэй харилцаанд өссөн нэг айлын хүүхдүүд байлаа гэж төсөөлөхөд ах, эгч, дүүд буюу хүүхэд бүрд өөр, өөрөөр мэдрэгддэг. Архины хамааралтай гэр бүлд өссөн хүүхдүүд зарим нь нас биед хүрээд архины хамааралд ордог ч зарим хүүхэд



“Хувь хүний зан чанар, нийгмийн дэмжлэгийн сүлжээ, ерөнхий эрүүл мэнд, өмнөх туршлага болон бусад нарийн төвөгтэй хүчин зүйлүүд нь аливаа үйл явдлыг гэмтлийн шинж чанартай байлгахад нөлөөлдөг”.

(Blue Knot Foundation, 2020. Organisational guidelines for trauma informed service.)

ялгаатай хүлээж авсан байдаг. Үүнээс харахад тухайн үйл явдал бие махбод, сэтгэл санаанд хэрхэн нөлөөлж, ямар нэг туршлагатай хэрхэн холбогдож байгаагаас үйл явдлыг гэмтлийн шинжтэй мэдрэх эсэх хамаарна. Сэтгэцийн гэмтлийг үүсгэж болохуйц үйл явдлууд нь мөн чанараараа хэн нэгэн эсвэл юмс үзэгдэл нөгөөгийнхөө эсрэг эрх мэдэлтэй байх хүчний ялгааг бий болгодог. Үүнээс шалтгаалан “Яагаад заавал би...” гэсэн гүн гүнзгий асуултыг төрүүлдэг. Эдгээр үйл явдал эсвэл нөхцөл байдлын талаарх тухайн хүний туршлага нь хүчгүйдэл болон амьдралын гүн гүнзгий философийн талаарх асуултыг төрүүлэхэд хүргэдэг байна.

Тохиолдол 1

...Авга ах маань “Чамайг хэн ч хайрладаггүй болохоор чамд хэн ч тусалж чадахгүй. Тийм болохоор хэнд ч хэлэх гэсний хэрэггүй, чамд угаасаа итгэхгүй” гэж хэлдэг тул айгаад надад түүний төрүүлдэг тэр муухай мэдрэмжийг би хэнд ч хэлээгүй. Үнэндээ манай гэрт намайг тоох хүн байхгүй болохоор авга ахын үгийг үнэн л гэж боддог. **БИ ЦАРАЙ МУУТАЙ, ХАЙРЛАГДАХААР САЙН ОХИН БИШ БОЛОХООР ЗӨВХӨН НАДАД ИЙМ ҮЙЛ ЯВДАЛ ТОХИОЛДДОГ БАЙХ. ХЭРВЭЭ БИ ТӨРӨӨГҮЙ БАЙСАН БОЛ..., БИ ЭНЭ ГЭРТЭЭ ТӨРӨӨГҮЙ БАЙСАН БОЛ НАДАД ИЙМ ЗҮЙЛ БОЛОХГҮЙ БАЙСАН БАЙХ. БИ Л ЭНЭ БҮХЭНД БУРУУТАЙ.**

Даван туулагч охин, 9 настай

Хууралт, доромжлол, ичгүүр, урвалт гэх мэт мэдрэмжүүд, чимээгүй байж өөртөө нууцыг хадгалах гэсэн оролдлого нь тухайн үйл явдлын талаарх хэрхэн бодох, мэдрэх туршлагыг бүрдүүлдэг. Ялангуяа бие махбод болон бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагчийн хувьд доромжлогдсон мэдрэмж хүчтэй дагалддагаас өөрийгөө муу эсвэл бохир хэнд ч хэрэггүй болсон мэтээр мэдрэхэд хүргэдэг бөгөөд улмаар өөрийгөө буруутгах, ичих, гэмших мэдрэмжийг илүү хүчтэй төрүүлдэг.

Эдгээр хүчин зүйлс нь хүний тэсвэр тэвчээрт нөлөөлдөг бөгөөд үүнийг “бэрхшээлийг даван туулах чадвар” гэж тодорхойлдог. 1990-ээд оны сүүлээр хийсэн судалгаануудаас чухалчилсан гол ололт нь хүүхдийн хүчирхийлэл, үл хайхрах байдал, гэр бүлийн бэрхшээл ба хожмын амьдралын эрүүл мэнд, сайн сайхан байдлын хоорондын хамаарлыг судалсан юм (SAMHSA, 2014). Уг судалгаагаар хүн хүүхэд насандаа ямар нэг таагүй, сөрөг мэдрэмж төрүүлэх зүйлтэй тулгарах нь түгээмэл зүйлийн нэг бөгөөд эдгээр сөрөг мэдрэмж, туршлага нь насанд хүрсэн хойно эрүүл мэнд, эрсдэлт зан үйл, эмнэл зүйн шалтгаант урт хугацааны өвчлөл зэрэг асуудлын суурь болж, холбоо хамаарал үүсгэж байдаг гэдгийг тодорхой харуулсан. Хүүхэд насны сөрөг туршлагад өртөх нь сэтгэцийн гэмтлийн стресс болон насанд хүрээд сэтгэцийн гэмтэлд дахин өртөх эрсдэл зэрэг нь мөн хоорондоо уялдаа холбоотой. Тиймээс гэмтлийн туршлага нь тухайн хүний, хүүхдийн насны нийгэм, сэтгэл зүй, хөгжил, соёлын хүчин зүйлүүдээс хамаарч хүн бүрд өөр, өөр байдаг.

Тохиолдол 2

...Амьдралд минь таарсан хүн бүр надад нэг л зүйлийг давтан сануулдаг. Хэрэв би хэн нэгэнтэй дотно болох юм бол заавал хохирдог бас хууртдаг. Надад итгэж болох найз, ер нь хэн ч байхгүй, бүгд намайг хуурсан. Миний хүүхэд насанд тохиолдсон тэр үйл явдлаас хойш би бусад “энгийн” хүнээс өөр болсон байж магадгүй. Намайг хорвоо дээр байгаа хамгийн муу хүмүүс л олж ирдэг. Эрүүл мэндийн олон асуудал байдаг болохоор би тууштай ажил хийж чаддаггүй. Миний дотор нэг зүйл байсаар л байдаг. Гэхдээ би юу хийх ёстойгоо мэддэггүй, үргэлж түүнтэй тэмцэж амьдардаг.

Даван туулагч эмэгтэй, 37 настай

Сэтгэцийн гэмтэл нь хүний суурь итгэл үнэмшил, үнэлэмж, зан үйл болон утга учиртай харилцааг дарангуйлдаг талаар бид өмнө тайлбарласан. Учир нь сэтгэцийн гэмтэл нь дасан зохицоход бэрхшээлтэй дурсамж болохыг бид маш сайн ойлгох хэрэгтэй. Гэмтлийн туршлагауд нь түр зуурын (гэмтлийн үйл явдлын тодорхой агшинд тохиолддог) болон бүтцийн шинж чанартай (нийгмийн болон эдийн засгийн тогтолцооны тэгш бус байдлын үр дүнд үүсдэг) байдаг. Гэмтэл нь тухайн хүнийг аливаа стрессийг даван туулахад нь туслах шинэ арга зам, тэр дундаа утга учиртай харилцааг дахин шинээр бий болгоход хүргэдэг.

Тохиолдол 3

...Би бүх зүйлийг нарийн төлөвлөдөг. Хэрэв надад гэнэтийн, төлөвлөх боломжгүй зүйл тохиолдвол би маш их стресстдэг. Найзуудтайгаа уулзах, гадагшаа гарах, бусадтай харилцах, аялалд явах гээд л бүх зүйл 100 хувь миний төлөвлөснөөр байх ёстой. Гадаад, дотоод бүх зүйл, хамт байгаа хүмүүсийн зан байдал, надад хэлэх үг гээд л бүгдийг би заавал урьдчилан боддог. Хэрвээ ингэж чадаагүй бол тухайн орон зай миний хувьд хар дарсан зүүд болон хувирдаг. Тэр цаг үед бэлдэж чадаагүй бол одоо юу тохиолдох бол гэдэг айдас түгшүүр л төрдөг. Энэ үнэхээр хэцүү. Бүх бие хөрж хөшиж, харанхуй буланд суугаад нуугдмаар болдог.

Даван туулагч эмэгтэй, 35 настай

Дээрх жишээнээс бид сэтгэцийн гэмтэлд өртсөнөөр тухайн хүн бодит орчноо алдаатай хүртэж хүлээж авах, амьдралд тохиох энгийн стресст хэтрүүлсэн хариу үйлдэл үзүүлэх, аюул тохиолдох гэж байна гэсэн байнгийн айдас түгшүүртэй байх гэсэн гэмтлээс үүдэлтэй тархинаас ирэх дохио нь бүх зүйлийг хянах, төлөвлөх оролдлого хийх улмаар гэмтлийн үеийн бие махбодын мэдрэхүй хүчтэй илэрдэг болохыг харж болохоор байна.

Сэтгэцийн гэмтэл нь хүний аливаа асуудлыг даван туулах хэвийн механизмыг дарангуйлдаг бөгөөд энэ нь тухайн хүний өнгөрсөн үеэс одоог хүртэлх хугацаанд хуримтлуулсан туршлагыг хуваагдмал байдалд оруулдаг. Өөрөөр хэлбэл гэмтлийг үүсгэж буй дурсамж тархинд асаалттай, байнгын идэвхтэй дохио буюу мэдрэлийн холбоос үүсгэдэг. Тухайн дохио нь үйл явдлаас хойш ямар хугацаа өнгөрснөөс үл хамааран тухайн дурсамжийг 5 мэдрэхүйгээр дамжуулан дахин тохиолдож буй мэтээр өдөөдөг. Энэ процесс нь үйл явдлыг бодит мэтээр мэдрүүлдэг.

Жишээлбэл, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч чанга дуу чимээ, хашхираан сонсоход цочирдон дахин аюулд өртөх гэж буй мэт мэдэрч болох ба улмаар үйл явдалд тохироогүй хэтэрсэн хариу үйлдэл үзүүлэх нь бий. Үүнийг “**зурсхийх бодол орж ирэх**” гэж нэрлэдэг. Бид заримдаа ямар нэг бодит үйл явдлаас өөрийн өнгөрсөн дурсамжийг санагалзаж чаддаг. Жишээ нь сүүтэй цай уухад ээжийн чанасан цай мэт амтагдахад ээжийнх нь цайгаа чанаж байсан үе нүдэнд үзэгдэх, аавтай адилхан хоолойтой хүнийг сонсоход аавынх дүр зураг толгойд нь буух, өөр хэн нэг хүний гунигт түүх сонсоход өөрийн түүхтэй адилхан санагдаж зүрх түгших, амьсгалахад хүнд болох, хоолой зангирах гэх мэт байдлаар илэрч болно.

“Зурсхийх бодол” орж ирэх үед тухайн хүний хувьд өдөөгч болж буй зүйл өнгөрсөн үеийн цочролд үйл явдлыг одоогийн цагт дахин мэдрүүлдгээс болж тухайн өдөөлтөд оюун санаа болон бие махбодод анхны гэмтлийн дурсамжийг сэргээдэг. Гэмтлийн дурсамжийг сэтгэл хөдлөл, таван мэдрэхүй болон анхны гэмтлийн туршлагыг санагдуулахуйц бусад нөхцөлүүд өдөөж болдгийг бид Модуль 11-ээс уншиж судалсан.

! Тохиолдол 4

...Эрэгтэй хүн том биетэй, том нүдтэй бол надад их аймаар санагддаг. Том эрэгтэй хүмүүс бүгд аймаар ч нүд нь том бол бүүр аймаар. Намайг хаашаа ч хөдөлсөн шууд харж чаддаг. Таны өрөөнд байгаа бамбарууш бөөрөнхий том товчин нүдтэй болохоор надад том хүний нүд шиг санагдаад бас намайг тасралтгүй хараад байгаа юм шиг санагдаад би айгаад байна.

Даван туулагч хүү, 7 настай

Зураг 3. Сэтгэцийн гэмтэлд үзүүлэх хариу урвалууд



Эх сурвалж: Пете Уалкер

Сэтгэцийн гэмтлээс үүдэлтэй стресст хариу үйлдэл зурагт харагдаж буй байдлаар илэрнэ. Стресст хэрхэн хариу үзүүлдэг тухайд дахин бататгахад аливаа асуудлаас эсвэл хүчирхийллээс зугтах, эсвэл гөлрөнгө, хөшингө байдалтай хөлдөх, хүчирхийлэл үйлдэгчтэй тэмцэхээс гадна бусдад байнга тал засах, бялдуучлах, долигонох зэрэг нь сэтгэцийн гэмтлийн хариу үйлдэл болон илэрнэ. Тухайн хүний сэтгэл зүйн онцлог, хөгжил, даван туулах чадвар, гэр бүлийн дэмжлэг, соёл зэргээс шалтгаалан стресст нөхцөлд ялгаатайгаар хариу үзүүлдэг байна. Магадгүй хөлдөх, хөших буюу ямар нэг хариу үзүүлэх чадамжгүй болдог үйлчлүүлэгчийн хувьд зарим мэргэжилтнүүд болон нийгэм, олон нийтийн зүгээс буруутгах, шүүх шүүмжлэх хандлага тохиолдлууд байдаг.

Стресст зугтах, зайлсхийх, хариу үйлдэл үзүүлэх нь эрүүл болон эрүүл бус хэлбэртэй ба эрүүл хариу үйлдэл нь хортой үр дүнгүй харилцаанаас зайлсхийх, бие махбодын хувьд аюултай нөхцөл байдлаас өөрийгөө холдуулах өөрөөр хэлбэл бодит аюулыг мэдэрч боломжтой бол түүнийг орхих боломжтой хариу үйлдэл үзүүлэхэд хүргэдэг. Харин сэтгэцийн гэмтлийн үед эрүүл бус хариу үйлдэл үзүүлэх нь буюу хэт албадлагын хандлага гаргах, үргэлж өөрийгөө завгүй байлгах, төгс зүйлд тэмүүлэх, хөдөлгөөнгүй суухад хүндрэлтэй байх, хэт ажиллах, аливаа зүйлд донтох, байнга ямар нэг айдастай байх гэх мэтээр илэрдэг. Эдгээр нь бүгд аюулыг даван туулах гэсэн оролдлого байдаг.

Дайтах тэмцэх хариу үйлдэл нь өөрийгөө хамгаалах үйл явц бөгөөд бусдыг гомдоох эсэх нь төдийлөн чухал байдаггүй. Хэдийгээр зарим тохиолдолд тэмцлийн хариу үйлдэл нь эрүүл тустай байдаг ч сэтгэцийн гэмтлийн үед тухайн нөхцөлд тохироогүй хүчтэй сэтгэл хөдлөлөөр илэрдэг. Жишээлбэл: хэн нэгний зан үйлийг хянах, өөрийгөө хэтрүүлэн дөвийлгөн бусдыг дорд үзэх, түрэмгий, бусдаас төгс төгөлдөр зүйл шаардах, хил хязгаараа алдах гэх мэт.

Дагжрах гөлрөх хариу үйлдэл нь тухайн аюултай тэмцэх, зугтахын оронд түр зогсдог өөрөөр хэлбэл заналхийллийн үед байгалийн чанараараа үхсэн мэт хөдөлгөөнгүй болох эсвэл унтаж буй мэт үйлдэл гаргахтай ижил юм. Эрүүл хөлдөх хариу үйлдэл нь анхаарал төвлөрөх, тухайн мөчид бүрэн орших зэргээр илэрдэг бол сэтгэцийн гэмтлийн үед эрүүл бус хөлдөх хариу үйлдэл нь диссоциаци буюу бие махбод, оюун санаа тусгаарлагдах, тархи манарах, шийдвэр гаргахад бэрхшээлтэй болж шинэ зүйлд хүрэх, туршихаас айх зэргээр илэрч болно.

Долигонох-бялдуучлах хариу үйлдэл нь ихэвчлэн бусдад таалагдах, хүн бүрд таатай сэтгэгдэл үлдээхтэй холбогдоно. Өөрөөр хэлбэл хортой таагүй харилцаатай хүмүүсийг өөрчлөхийн тулд маш их хугацаа зарцуулж илүү их зүйлийг хийж сурах, ингэснээр аюулыг багасгах зарчмаар үйлдэгддэг. Сэтгэцийн гэмтлийн үед эрүүл бус хариу үйлдэл үзүүлэх нь хэт хамааралтай болох, хүчирхийлэлтэй харилцаатай үлдэх, улмаар өөрийгөө алдах гээх, хил хязгаараа алдах гэх мэт үйлдлээр илэрч болно.

Олон давтагдах даамжирсан сэтгэцийн гэмтэл үүсгэж болохуйц үйл явдал нь уртдаа тухайн хүнд комплекс гэмтлийн дараах стресст эмгэг үүсгэх эрсдэлийг дагуулж байдаг. Хүүхэд насанд сэтгэцийн гэмтэлд өртөх нь комплекс гэмтлийн дараах стресст эмгэгийг үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Энэ нь хүүхдийн хөгжил, зан байдал, өөрийгөө үнэлэх, хандах зэрэгт нөлөөлж улмаар энэ нь тухайн хүүхдийн нэгэн хэсэг болж өсөх насны хөгжлийн бүрэлдэхүүн болдог.

Сэтгэцийн гэмтлээс үүдэлтэй урт хугацааны комплекс гэмтлийн дараах стресст эмгэгийн (complex PTSD) шинж тэмдэг нь Гэмтлийн дараах стресст эмгэг (PTSD)-ийн ерөнхий шинэ тэмдэгтэй төстэй. Олон улсад гэмтлийн дараах стресст “эмгэг эсвэл өвчлөл” буюу “disorder” гэдэг томъёолол нь сэтгэцийн гэмтэлд өртсөн хүний хувьд тохирохгүй байгаа талаар сүүлийн жилүүдэд судлаачдын дунд хурцаар яригдаж байна. Комплекс гэмтлийн дараах стресст өртсөнөөр дараах шинж тэмдгүүд илэрч болно. Үүнд:

- Гэмтэл үүсгэсэн тохиолдлыг санагдуулахуйц зүйлийг харах, мэдрэх, сонсох зэрэг таван мэдрэхүйгээр өдөөгдөж өөрийн ухамсарт хяналтгүйгээр дахин цочрол (шоконд) орох, “зурсхийн бодогдох”, тухайн цаг үед үйл явдал дахин давтагдаж буй мэтээр бие махбод мэдэрснээр бодит нөхцөлд хэтэрсэн, тохироогүй хариу үйлдэл үзүүлэх
- Тухайн хүн гэмтэл үүсгэсэн тохиолдлыг санагдуулах тэр байдлаас оюун санаа, зүрх сэтгэл, бие махбодын хувьд зугтаадаг, гэмтэлтэй холбоотой зүйлсийг санах хүсэлгүй байдаг буюу сэтгэл зүйн хувьд хүмүүсээс зай барих, зайлсхийх, өөрийгөө тусгаарлах
- Сэтгэл тавгүйрхэж түгших, сэтгэлийн дотоод түгшүүр, зовууриас зайлсхийхийн тулд архи, мансуурах бодис болон бусад зүйлд донтох, хамааралд орох эрсдэл өндөрсөх
- Ичгүүр, буруутай мэдрэмж төрөх
- Сэтгэл хөдлөл тогтворгүй, зохицуулахад хүндрэлтэй болох
- Анхаарлаа төвлөрүүлэхэд хүндрэлтэй байх
- Өөрийгөө гэр бүл, найз нөхөд зэрэг дотно харилцаанаас тусгаарлах
- Хүн хоорондын харилцааны бэрхшээлүүдтэй тулгарах
- Өөрийгөө гэмтээх оролдлого хийх
- Амархан айх, цочимтгой болох, сандарч мэгдэх
- Сэтгэл гутралд орж, өдөр тутмын амьдралдаа сонирхолгүй болох, ядрах, байнгын эрч хүчгүй мэт мэдрэх
- Стресс архагшин ужгирснаар бие махбодыг дааврын өөрчлөлтөд оруулах, улмаар дархлааны системийн гажуудал үүсэх. Өөрөөр хэлбэл өвчлөмтгий болох, арьс болон харшлын гаралтай өвчлөлтүүд, үе мөчний өвчлөлтүүдэд өртөмхий болох (Gabor Mate, 2003) бие махбодын өвдөлт, зовуурь тэр дундаа нийтлэг шинж тэмдгүүд болох толгой

өвдөх, хоол боловсруулах эрхтэн системийн үйл ажиллагааны доголдол, цээжээр хөндүүрлэн өвдөх, амьсгалахад хүндрэлтэй байх зэрэг нь сэтгэл зүйн тогтворгүй байдал зэрэгтэй хоршсоноор хүн орших хүсэлгүй болох улмаар амиа хорлох бодол, төлөвлөгөө гаргах, үйлдэл хийх


- Насанд хүрсэн хүн хөдөлмөрийн чадвар алдагдан сульдах, бусадтай харилцах харилцаа нь өөрчлөгддөг (НҮБ-ын Хүн Амын Сан “Дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн эдийн засгийн өртөг зардлын тооцоо” судалгааны тайлан) бол хүүхдийн хувьд сурлагадаа муудах, анхаарал сарних гэх мэт.

1.2

СЭТГЭЦИЙН ГЭМТЛИЙН ШИНЖ ТЭМДЭГ БА НӨЛӨӨ

Сэтгэцийн гэмтлийн гол шинж чанар нь хувь хүний туулж өнгөрүүлсэн түүхийг сарниулж, өөрийгөө болон гадаад ертөнцийг бодитоор мэдрэхэд саад учруулдаг. Өөрөөр хэлбэл гэмтлийн талаарх дурсамжууд нь бодит цаг буюу одоо цагийг тасалдуулан зөвхөн тухайн үйл явдал бүхий цаг хугацаанд гацна. Түүнчлэн гэмтлийн талаарх дурсамжийг ойлгомжтой, нэг бүрчлэн илэрхийлэх боломжгүй ч ой дурсамжид нягт хадгалагддаг. Энэ бол болсон үйл явдлын эсрэг үзүүлж буй үгэн бус хариу үйлдэл бөгөөд өнгөрсөнд болсон ч одоог хүртэл тухайн хүний бие махбод, сэтгэл зүй, сэтгэл хөдлөл танин мэдэхүйд үргэлжилсээр байдаг. Гэмтлийн талаарх орчин үеийн онолын бас нэгэн анхдагч судлаач Бессел Ван Дер Колк “Гэмтэл бол зөвхөн өнгөрсөн хугацаанд тохиолдсон үйл явдал биш, энэ нь тухайн болж өнгөрсөн зүйлсээс оюун ухаан, тархи, бие махбодод үлдээсэн үл мөр» гэж тайлбарлажээ. Хүүхэд насандаа сэтгэцийн гэмтэлд өртсөнөөр тухайн хүүхдийн “би”-ийн талаарх үзэл сөргөөр өөрчлөгдөн, хөгжилд нь олон талын сөрөг үр дагаврыг авчирдаг.

ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ ХӨГЖИЛ



Хүүхдийн эрүүл хөгжилд дээрх зурагт харуулсанчлан тухайн бүрэлдэхүүн хэсгүүд нэг нэгнээ нөхцөлдүүлэн нэг бүхэл болох ба улмаар яг л баримлын шавар шиг ямар ч хэлбэрт орж болно. Өөрөөр хэлбэл хөгжил ямар ч хэлбэрээр хөгжин тэлж болох бөгөөд энэ нь хүүхдийн “би” нь хөгжлөө даган тасралтгүй хөгжиж байдаг. Бие махбод, оюун санаа, сэтгэл хөдлөл хөгжихийн хэрээр бусадтай итгэлтэй, нээлттэй харилцааг бий болгоход суралцдаг.

Хүчирхийлэл хүүхдийн хөгжилд нөлөөлөх нь

Харин сэтгэцийн гэмтэлд өртсөн хүүхэд бие махбод, оюун санааны хувьд хөгжиж байгаа мэт боловч сэтгэл хөдлөл, сэтгэл зүйн хөгжил зогсонги байдалд ордог. Учир нь тухайн хүүхдийн бие махбод, оюун санаа нь одоо цагт амьдарч байгаа боловч өмнөх сэтгэцийн гэмтлийн нөлөө нь үргэлжилсээр байдаг тул байнга аюултай нөхцөлд байна гэдэг дохио бие махбод, оюун санаанд нь илгээгдэж байдаг. Энэ нь хүүхдийн хөгжлийн бусад бүрэлдэхүүн хэсэгт нөлөөлөх ба улмаар бусад хүмүүстэй итгэлт харилцааг бий болгох чадварыг буурдаг. Түүнчлэн өөрийнх нь итгэдэг насанд хүрсэн хэн нэг хүний зүгээс ёс зүй, ёс суртахууны хувьд байнга давтамжтайгаар сөрөг нөлөө үзүүлж байдаг бол сэтгэцийн гэмтлийн илаарьших үйл явцад бэрхшээл үүсгэдэг.

Сэтгэцийн гэмтэлд өртсөн хүүхдэд нийтлэг дараах өөрчлөлтүүд үүсэж болно.

Сэтгэл хөдлөл

- Хэт эмзэг цочмог болох
- Бусдад үл итгэх
- Зожгирах
- Хорлон сүйтгэх
- Өш хонзон санах
- Түрэмгий болох
- Хулгай хийх
- Худал ярих
- Эрсдэлт зан үйлд татагдах
- Мухар сүсэгт автах
- Өөрийгөө гэмтээх-түлэх-зүсэх
- Амиа хорлох бодол тээх, төлөвлөх, гүйцэтгэх
- Хэт хамааралтай болох

Зан үйл

- Тогтворгүй байх
- Уур бухимдалтай болох
- Сэтгэлээр унах
- Шоконд орох
- Түгшүүрт автах, сандарч мэгдэх
- Түргэн цочир ууртай болох
- Олон ааш гаргах
- Сэтгэл гутралд автах
- Уйтгар гунигт автах
- Ямар ч тусламжгүй мэт цөхрөх
- Бодит орчны нөхцөлийг мэдрэхгүй байх

Танин мэдэхүйн

- Өөрийн үнэлэмж доогуур болох
- Өөртөө итгэлгүй болох
- Айдас түгшүүрт автах
- Эргэлзэн будилах
- Анхаарал тогтворгүй болох
- Шийдвэр гаргах чадвар сулрах
- Ой санаж будилуу болох
- Орон зайн ба цаг хугацааны баримжаалал алдах
- Улигт бодолд автаж хөшингө болох

Бие махбод

- Өвдөлт, хөхрөлт, улайлт, урагдтал, шарх, бэлэг эрхтэн, анусны нүх эсвэл амнаас цус юм уу шингэн шүүрэх
- Хүнд, хөнгөнөөр бие засахад өвдөлттэй байх, энэ зовуурь арилахгүй байх
- Суултуур болон хөтөвчинд бие засаж сурсан боловч өтгөн шингэнээ санамсаргүй алдах;
- Жин нэмэх эсвэл жин алдах
- Өөрийгөө арчилж анхаарахаа болих
- Орондоо шээх

Хүүхдийн нас, сэтгэхүйн хөгжлийн үе шатнаас шалтгаалан бэлгийн хүчирхийлэлд өртсөнөөр нийтлэг илрэх шинж тэмдгүүд:

0-2 нас

- Үйл явдал байнга бодогдох харагдах
- Хэл яриа хөгжил удаашрах, ярихгүй шулганахгүй байх
- Тоглохгүй, инээхгүй байх
- Хэт уур бухимдалтай, байнга уйлагнах
- Анхаарал тавихыг эерэг болон сөрөг байдлаар шаардах
- Түрэмгий зан авир гаргах (хүүхэд болон тоглоомоо урах маажих гэх мэт)
- Урвуу зан үйл буюу сурсан чадвараа алдах (хөтөвчинд бие засаж сурсан байсан бол чадахгүй болох, чадвараа алдах гэх мэт)
- Амархан цочих
- Үйл явдал санагдуулахуйц хүнээс айх
- Эцэг эх, асран хамгаалагчаас алдах вий гэхээс айх
- Нүдэн харилцаа хийхгүй байх
- Унтах зөв зуршилгүй байх, унтаж чадахгүй байх, орондоо шээх

3-6 нас

- Анхаарал төвлөрөхгүй байх
- Тухайн нас сэтгэхүйн онцлогт тохирсон аливаа зүйлийг суралцах ур чадвар муу байх
- Суралцахад бэрхшээлтэй байх
- Ууртай, түрэмгий зан авир их байх ба олон нийтийн газар “жүжиг тавих” өөрөөр хэлбэл гэртээ гаргадаггүй зан байдал гаргах, олон хүний анхаарал татах үйлдэл хийх
- Болсон үйл явдлыг дуурайн хийх, үзүүлэх, тоглох
- Найзуудтай болж чадахгүй байх ба бусдад итгэхгүй байх өөрийгөө буруутгах
- Өөртөө итгэлгүй, түгшүүртэй, гунигтай байх
- Хоолны дуршил буурах, шингэхгүй байх улмаар толгой, гэдэс өвдөх зэрэг биеийн өвдөлтүүдтэй болох
- Унтах зөв зуршилгүй байх, хар дарж зүүдлэх

6-12 нас

- Сургуульд явахаас дургүйцэх, самбарын өмнө гарч асуултад хариулахаас айх, шалтгаангүй айх, нойр хулжих, дотор муухайрах, чичрэх, салгалах, сургуулиас зугтах
- Анхаарал сарних, хэт хөөрлийн байдлаас болж анхаарал хэт сарних, анхаарлаа төвлөрүүлэн барьж чадахгүй байх
- Суралцах чадвар сулрах, суралцах үйл ажиллагаанд нь хүндрэл, бэрхшээл гарах (унших, бичих, тооны үйлдэл хийх чадвар сулрах гэх мэт)
- Сурлагаар хоцрогдох, өдөр тутмын хичээлдээ анхаарал төвлөрүүлж чадахгүйгээс болоод сурлагаар хоцрох, өөртөө үл итгэх байдал илрэх
- Зан үйлийн сөрөг өөрчлөлт буюу бүрэг зожиг болох, худлаа онгирох, уур уцаартай, түгших, зовних
- Хариугаа авах, өшөө авах талаар бодох (зарим тохиолдолд жижиг амьтан тарчлаах, зовоох үйлдлүүд гаргах)
- Болсон үйл явдал давтагдах вий гэхээс айх
- Өөртөө хэт анхаарах эсвэл өөрөөсөө зайлсхийх зэрэг гадаад үзэмжээр илэрхийлэх
- Хэн нэгэнтэй сэтгэл зүйн хувьд ойр байх хайрлагдахаас айх

12-18 нас

- Уур бухимдлаа гадагшлуулахдаа түрэмгий авирлах, томчуудыг эсэргүүцэх, сөргөлдөх, нийгмийн хэв журмыг зөрчих магадлал өсөх
- Өөрийгөө бусдад хүлээн зөвшөөрүүлэхийн тулд архи, мансууруулах бодис хэрэглэх, танхайрах, бэлгийн харилцаанд замбараагүй орох аргуудыг хэрэглэх. Зарим тохиолдолд амиа хорлох хүртэлх хэлбэрт шилжих.
- Үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцааны хүрээлэл өөрчлөгдөх, өмнө нь эсэргүүцэж байсан үнэлэмж, баримжаалал бүхий хүмүүстэйгээ нэгдэж нийлэх, эсхүл зожгирч ганцаардах, өөрийгөө чамлах байдал ажиглагдах
- Өөртөө итгэлгүй, хэт их айдас түгшүүр, сэтгэлээр гутрах, улмаар өөртөө хэт анхаарах эсвэл өөрөөсөө зайлсхийх
- Зан ааш огцом хувирал цөөнгүй ажиглагдах. Найрсаг байсан хүүхэд түрэмгий, идэвхтэй байсан хүүхэд идэвхгүй болох гэх мэт.

Судлаачид дунд сургуулийн суралцагчдад танхимын хичээлийн явцад хамгийн тод ажиглагдах гэмтлийн нөлөөний жагсаалтыг хураангуйлсан байдаг. Үүнд: (Trauma Conference, 2020)

- Анхаарал төвлөрөх, хичээлд оролцох, тогтоох, эргэн санахад бэрхшээлтэй болох
- Маш их хичээл таслах хандлагатай байх
- Сэтгэл хөдлөлийн зохицуулалттай холбоотой бэрхшээлүүд үүсэх
- Эрсдэл хийхээс айх
- Товлосон хугацаа, шалгалт, бүлгийн ажил, олон хүмүүсийн өмнө ярихаас санаа зовох
- Стресстэй үедээ уурлах, арга мухардах, эсвэл салангид байх
- Зайлсхийх, өөрийгөө тусгаарлах
- Хүн хоорондын эрүүл бус харилцаатай болох

Үүний нэг жишээ нь “Хөөрхөн Зүрх” ТББ-д нийгэм-сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ авч байсан сургуулийн насны хүүхдүүдийн нийтлэг жишээг цуглуулахад хичээлийн хоцрогдол, хичээл шалтгаангүйгээр таслах, үе тэнгийн найз нөхөдтэй харилцаа үүсгэж чадахгүй байх, ганцаардах, аливаа зүйлд удаан хугацаанд тууштай байж чадахгүй байх зэрэг шинжүүд мөн тулгардаг.

 **Тохиолдол 5**

...Манай ангийн сурагчид тохиолдсон асуудлыг бид хамтарсан багаар хэлэлцэн дэмжиж байгаа ч ангийн багшийн зүгээс хүүхдээ ажиглахаар сурагч маань ангийн ажилд оролцох их дургүй болсон. Юу болсон, бас болохгүй байгаа талаар асуухаар байнга “Зүгээр ээ, багшаа” гэж хариулдаг юм. “Зүгээр” гэдэг хариултын цаана “зүгээр биш” байгаа нь хичээлээ таслах, анги дотроо найзуудтай болохгүй байгаагаас, багштайгаа ойр байхыг хичээдэг ч өөрийгөө илэрхийлж чадахгүй байгаа зэрэг олон жишээнээс харагддаг. Саяхан ангиараа агаарт гарч эцэг эхчүүд хүүхдүүддээ идэх хөнгөн зүйл бэлдэн өгч явуулан, зарим эцэг эх, асран хамгаалагчид хүүхдүүдийг хамт хариуцан явсан юм. Ууланд анги хамт олноороо тоглож хүүхдүүд хөгжин гүйлдэж байхад “Зүгээр ээ, багшаа” гэсэн сурагч минь модны ард суугаад цаашаа хараад ганцаараа үйлж байсан.

... дугаар сургуулийн ангийн багш

Хүүхэд насны сэтгэцийн гэмтэл зөвхөн тухайн цаг үед хор нөлөө үзүүлээд зогсдоггүй ба даван туулж буй онцлогоос хамааран урт хугацааны хор хохирол учруулдаг. Үүний нийтлэг хэлбэрээс дурдвал дараах асуудлууд үүсэх талтай:

- Архидалт, согтууруулах ундааны хэтрүүлсэн хэрэглээ
- Уушгины архаг бөглөрөл
- Сэтгэл гутрал
- Түгших эмгэг
- Ураг амьгүй болох
- Эрүүл мэндийн шалтгаантай амьдралын чанар муудах
- Хууль бус бодисын хэрэглээ буюу сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, мансууруулах бодис
- Зүрхний ишеми буюу зүрхний титэм судас нарийсаж зүрхний булчинд очиж байгаа цусан хангамж дутагдах өвчин
- Элэгний өвчин
- Дотно хамтрагчийн зүгээс хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй
- Бэлгийн олон хамтрагчтай байх
- Бэлгийн замын халдварт өвчин
- Тамхидалт
- Илүүдэл жин
- Амиа хорлох оролдлого
- Хүсээгүй жирэмслэлт зэрэг эрсдэлийг дагуулдаг.

Тохиолдол 6

...Аавыг уугаад гэртээ ирэхэд ээж, дүү 2 ойртож чадахгүй болохоор эрэгтэй хүүхэд илүү тэнхээтэй гээд аавыг өргөж унтуулах ажил надад оногддог байсан. Хичнээн хэцүү байсан ч би л аавыг тайвшруулж унтуулах ёстой. 10 жилийн сурагч байсан болохоор найз нөхдөөсөө их ичиж, бас гутардаг байсан. Харин одоо би сэтгэл тавгүй үедээ уух гээд, уухаараа хэтрүүлээд байдаг боллоо.

24 настай, эрэгтэй

Үүнээс бид сэтгэцийн гэмтэл нь тухайн хүний насан туршийн амьдралд тал бүрээр нөлөө үзүүлэн даван туулах шаардлагатай болдгийг өргөн хүрээнд тусган ойлгох шаардлагатайг харуулж байна.

Үүнээс гадна олон жишээг бид “Дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн эдийн засгийн өртөг зардлын тооцоо” 2020 онд гарсан НҮБ-ын Хүн Амын Сангийн судалгааны тайлангаас дэлгэрүүлэн уншиж болно.

Тохиолдол 7

...Миний хүүхдэд ийм зүйл тохиолдсонд үнэхээр итгэж чадахгүй нь. Би өөрөө бие муутай хүн болохоор хүүхдээ хангалттай анхаарч чадаагүйгээс болж ийм зүйл болсон байх. Үүнд би л буруутай. Хонь хариулаад гүйж явахдаа надад тохиолдсон зүйл миний хүүхэд насыг бүрэн өөрчилсөн. Түүнээс хойш би зөвхөн тэр дурсамжийг хэрхэн мартаж вэ гэж цаг, минут бүрийг завгүй өнгөрөөдөг болсон. Идэх хоол, унтах нойроо ч мэдэхгүй болсон. Эцэст нь эрүүл мэндийн маш олон асуудалтай болсон.

42 настай, эмэгтэй

1.3

СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛД ДАХИН ӨРТӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД АНХААРАХ НЬ

Дахин гэмтэл гэдэг нь тухайн хүний даван туулж буй гэмтэлтэй төстэй аливаа нөхцөл байдал, орчин бөгөөд энэ нь анхны гэмтэлтэй холбоотой хүнд хэцүү мэдрэмж, хариу урвалыг өдөөдөг. Өөрөөр хэлбэл дахин сэтгэцийн гэмтэлд өртөнө гэдэг нь хохирогч, даван туулагч өмнө нь болсон үйл явдлыг ухамсарт болон далд ухамсарт дахин мэдрэх, дахин туулахыг хэлнэ.

Тухайн болсон үйл явдлыг бага ярих, бодох тусам тогтмол бодох нь буурч болно. Гэвч тодорхой үйл явдлууд тухайн дурсамжийг сэдрээх боломжтой. Тухайлбал цагдаагийн газар байнга мэдүүлэг өгөх, эрүүл мэндийн үйлчилгээ авч буй тохиолдолд удаа дараалан очихдоо эмнэлгийн ажилтан бүрд түүхээ ярих гэх зэрэг байж болно. Тиймээс бүх хувь хүн, ажилтнууд, систем/байгууллагын бүх төвшний тусламж үйлчилгээнд дахин гэмтээх эрсдэл байдаг.

Тохиолдол 8

...Намайг бүх юмаа ярь гэсэн. Би яримааргүй байсан ч ярь гээд шахаад байсан болохоор би ярьсан. Тэр өрөөнөөс гараад л тэр хүн дээр дахиж очмооргүй (мэргэжилтэн хэлсэн ба хүүхдийн үгээр оруулав) санагдаад орой нь би муухай зүүд зүүдэлсэн. Дахиад хэнтэй ч юу ч яримааргүй санагдсан. Би балаараа гараа хатгаад зөндөө нүх гаргасан. Орой болохоор надад бүр хэцүү байдаг юм. Тэр өдрийн орой би гэрлээ нэг ч унтраагаагүй бас нүдээ аниагүй. Аймаар байсан.

12 настай, эмэгтэй

Тухайлбал үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүд сэтгэцийн гэмтлийн талаар ойлголт мэдлэг хангалтгүй байх, хохирогч/даван туулагчийг буруутгах, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын мэргэжилтнүүдийн хоорондын уялдаа холбоогүй байдал, байгууллага сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний бодлогогүй байх зэрэг нь үйлчлүүлэгчийг дахин гэмтээх эрсдэл дагуулдаг. Энэ талаар бид хоёрдугаар бүлэгт сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний тухай дэлгэрэнгүй тайлбарлах болно. Дахин гэмтэх нь ихэвчлэн санамсаргүй байх ба дахин гэмтэл учруулж болзошгүй зарим «илэрхий» үйлдлүүд хэдийгээр байдаг ч өмнө дурдсанчлан гэмтлийг өдөөж болох өдөөгчүүдийг агуулсан тодорхой бус үйлдэл, нөхцөл байдал нь дахин цочролд оруулахад хүргэдэг.

Тохиолдол 9

...Дахиад тэр хүн дээр оч, одоо энэ ажилтан чамайг хариуцна гээд л бүх хүнд дахиад эхнээс нь ярина гэдэг ямар хэцүү гээч. Тэгснээс хэний ч тусламжийг авахгүй байсан нь илүү дээр санагдсан.

16 настай, эмэгтэй

Олон удаа сэтгэцийн гэмтэлд өртсөн хүмүүсийн сэтгэцийн гэмтлийн шинж тэмдэг нь нэг удаа өртсөн хүмүүстэй харьцуулахад илүү хүнд байх нь олонх тул дахин гэмтэл авах нь ихээхэн санаа зовоосон асуудал юм. Олон удаа сэтгэцийн гэмтэл авсан хүмүүсийн сэтгэл засалд хамрагдах хүсэл эрмэлзэл буурсан байдаг. Бэлгийн хүчирхийллийн аль ч төрлүүд нь сэтгэцийн гэмтэлтэй болгож үлдээх эрсдэл дагуулдаг тул гэмт үйлдлийг нэг нь нөгөөгөөсөө хүнд эсхүл хөнгөн гэж ялгаж болохгүй юм. Харин сэтгэцийн гэмтлийг даван туулах нь тухайн хүний сэтгэл зүйн байдал, дэмжлэг бүхий гэр бүл, хамт олон, орчин байгаа эсэх зэргээс хамаардаг болохыг бид өмнө сэтгэцийн гэмтлийн тухай тайлбарлахдаа дурдсан.

Эдгээр хүчирхийллийн төрлүүдийг дэмжиж буй хүчин зүйлс нь манай нийгэмд бэлгийн хүчирхийллийг өөгшүүлэгч соёл байгаагийн энгийн жишээг бид албан газартаа ажилтан хоорондын бэлгийн сэдэлтэй хошигнол, эрчүүд хоорондын биеэ шоглох, даапаалах зэргээс илэрхий харж болно.

Бэлгийн хүчирхийллийн соёл

Нийгэмд хүчирхийллийг хэвийн мэт сууршихад нөлөөлдөг гол хүчин зүйл бол бидний амьдралд хэвийн мэт шингэсэн өдөр тутмын үг, үйлдэл, соёл, тогтолцооны асуудлыг бид өргөн хүрээгээр харах, ойлгох, анзаарах шаардлагатай юм.

Учир нь хүчирхийллийн талаархи ойлголт мэдлэг хангалтгүй, хүчирхийллийн шинжтэй үйлдэл ноцтой хохирол учруулаагүй бол байдаг л зүйл мэтээр өөхшүүлэх нь хүрээгээ тэлж үйлдлийг давтагдах, даамжирч хүндрэхэд нөлөөлөх гол хүчин зүйл болдог.

Бэлгийн хүчирхийллийн хувьд бид хэвийн мэт хүлээн зөвшөөрөхөд хүргэж байгаа нийтлэг үг хэллэгээр үйлдлийг хэвийншүүлэх хэлбэр нь олон нийтийн газарт өдөх, хоргоох, элдэв үг шидэх, хувийн орон зай, биед халдах, порнографик зураг, бичлэг илгээх, Эрчүүдийн дундах 18+ хошигнол, бэлгийн хүчирхийлэл агуулсан наргиа, хошигнол хийх, “Эр хүн шиг л бай” гэж ятгах. Улмаар доромжлолт үйлдлээр хэвийншүүлэх хэлбэр нь албадлага, шахалт үзүүлэх, зөвшөөрөлгүйгээр илж, таалах, хохирогчийг буруутгах, хүлээн зөвшөөрөгдөөгүй зураглал, төсөөлөл бий болгох, олон нийтийн газар бэлэг эрхтнээ үзүүлэх гэх мэтээр улам даамжирдаг.

Цаашлаад давуу хүчээр хүчирхийллийг өөхшүүлэх буюу хуурч, мэхлэн хамгаалалтгүй бэлгийн харьцаанд орох, порно кино, зураг үзүүлэх, дагаж мөрдөх, өдөж хоргоох зэрэг үйлдэлээр нарийвчлалтай үйлдэгддэг байна.

Эдгээр үйлдэлийг бид хэвийн мэтээр үзсэнээр илт танигдахуйц хүчирхийлэл буюу хор уршиг нь тухайн хохирогч даван туулагч амь насаа алдах, хүчингийн гэмт хэргийн хохирогч болох, альваа төрлийн мансуурах бодис болон зан үйлийн хамааралд орох зэргээр бид хүчирхийллийг зөвхөн нүдэнд харагдах, илт мэдэгдэх хүчирхийллээр хязгаарлан харах нь өрөөсгөл юм.

Иймд бид сэтгэцийн гэмтэлд дахин өртөхөөс хэрхэн сэргийлэх вэ?

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч/даван туулагч дахин хэзээ ч сэтгэцийн гэмтэлд өртөх магадлалтай тул сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээ үзүүлэх нь чухал гэдгийг дахин сануулъя. Тиймээс хохирогч/даван туулагчтай уулзалт хийж байх үедээ уулзалт эсвэл үнэлгээний зорилгоо ямагт санах хэрэгтэй ба зорилгоос хазайж болохгүй. Эмнэл зүйн болон хууль эрхзүйн үйлчилгээний хүрээнд дахин сэтгэцийн гэмтэлд өртөх магадлал илүү өндөр байдаг. Тухайлбал эмнэл зүйн оношилгоо, үнэлгээний хүрээнд тухайн хүний бие махбодыг шинжлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо үйлчилгээ үзүүлж байх явцад биед нь хүрэх

нь үйлчлүүлэгчийн хувьд өдөөгч байж болзошгүй учраас илүү хянамгай хандах шаардлагатай юм. Хууль эрхзүйн үнэлгээний хүрээнд баримт нотолгоо цуглуулах бөгөөд эмнэлгийн тусламж үйлчилгээ шиг асран халамжлах шаардлагагүй хэдий ч тухайн мэргэжилтэн сэтгэцийн гэмтлийг сэдэрээхээс сэргийлэн харилцах ёстой. Иймд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ямагт хангаж ажиллахад анхаарах ёстой.

Хохирогч/даван туулагчтай ажиллаж буй бүхий л мэргэжилтнүүд нийгмийн ажлын экологийн загварыг мэдэж байвал зохилтой ба тэр дундаа тухайн үйлчлүүлэгчийн нийгмийн харилцаа, дотоод сэтгэл зүйн үйл явц хэрхэн явагдаж болох нөхцөл байдлыг анхаарах, анзаарах шаардлагатай юм. Үйлчлүүлэгчтэй итгэлт харилцааг бий болгох нь хамгаас чухал тул таны асууж буй асуулт дахин сэтгэцийн гэмтэлд оруулж болзошгүйг эрсдэлийг нэмэгдүүлэх магадлалтайг ямагт анхаарах хэрэгтэй. Дараах зөвлөмжийг харна уу.

1. *Сунжирсан урт ярилцлага хийхээс татгалзах* – Хохирогч/даван туулагч урт удаан ярилцлагаас дахин сэтгэцийн гэмтэлд өртөх магадлал өндөр. Учир нь урт, сунжирсан ярилцлагын туршид даван туулагчийн бие махбод, оюун санаа тухайн сэтгэцийн гэмтэлд өртсөн цаг мөчид гацсан, саатсан байдаг бөгөөд тухайн хүний бие махбодын бүхий л мэдрэхүй үйл явдлыг сэргээн мэдэрч, ажиллаж байдгаас одоо цагт төрж буй мэдрэмж улам ярвигтай болно. Хэрэв өдөөгдөж буй нь танд анзаарагдаж, мэдрэгдвэл ярилцлагыг даруй зогсоох, дараагийн уулзалтыг илүү богино хугацаатай байлгахад анхаарах шаардлагатай. Үүнд мөн хүүхдийн нас сэтгэхүйн онцлогийг харгалзах шаардлага нэн чухал. Жишээлбэл, бага насны хүүхдийн тархи дүрслэл багатай хязгаарлагдмал байдаг.
2. *Мэргэжилтэн өөрийгөө мэдрэх, анзаарах* – Таны асуулт, ярьж буй зүйлс хохирогч/даван туулагчийг дахин сэтгэцийн гэмтэлд оруулах магадлалтай. Учир нь мэргэжилтэн өөрт төрж буй мэдрэмж, мэдрэхүйг анзаарахгүй байснаар ярилцагчийнхаа тухайн цаг үед гарч буй мэдрэмжүүдийг анзаарахгүй өнгөрөх, эсвэл ялгаварлан гадуурхах, өөрийн мэдрэмжээрээ дүгнэх хандлага гаргах магадлалтай.
3. *Тэвчээртэй хандах* – Хохирогч/даван туулагчийг нэг дор бүх мэдээлэл өг гэж шаардахгүй байж ба түүнд итгэлт харилцаа явагдаж буйг эелдгээр сануулж болно. Даван туулагчийн биеийн хэлэмж болон хандлагыг анзаарах. Ярилцах аргыг тухайн хүний нас сэтгэхүйн онцлогт тохируулан өөрчлөх, ялгаатай аргуудыг турших, даван туулагчийн гаргаж буй хариу үйлдэлд хүлээцтэй хандах.
4. *Тогтмол, тогтсон горимтой байх* – Хохирогч/даван туулагчтай тогтсон өдөр цагт уулздаг байх, уулзахаар товлосон цагаа аль болох өөрчлөхгүй байх нь түүнд аюулгүй танил гэх мэдрэмж төрүүлнэ.
5. *Ирээдүй гарч болзошгүй өдөөгчийг тодорхойлох* – Аюулгүй ба аюулт мэдрэмж төрүүлэх, өдөөгч болох хүчин зүйлсийг нь бичүүлэх, ярилцах.
6. *Зөвшөөрөл авах* – Хэрэв аюултай, тухгүй мэдрэмжтэй, өөрөө хүсэхгүй бол асуултад хариулахгүй байж болно гэдгийг сануулах.
7. *Нээлттэй байх* – Асуулт нь хэт нэг талыг баримталсан, даван туулагчид санаа өгөхүйц чиглүүлсэн асуулт асуух, өөрийн хандлагаар таамаглал дэвшүүлэхээс татгалзаж зарим шаардлагатай нээлттэй асуултуудыг алгасахгүй байх. Нээлттэй бөгөөд бүтэц бүхий асуумж байж болно. Тухайн хүний хувьд анх удаа болсон явдлын тухай ч ярьж байж болно.
8. *Тайвшруулах* – Тухайн ярилцлагын явцад гарч буй сэтгэцийн гэмтлээс үүдэлтэй илрэх шинж тэмдгийг бууруулах, тайвшруулах дасгал хийх. Мөн ганцаараа байгаа тохиолдолд аюултай, чочмог хямралд өртүүлэхүйц мэдрэмж төрсөн үед өөрөө бие дааж хэрхэн хийхийг заах.

9. *Зөвшөөрөл авах* – Тухайн хүний биед хүрэхдээ зөвшөөрөл авах. Яагаад энэ үнэлгээг хийж байгааг өөрт нь дэлгэрэнгүй хэлж тайлбарлах.
10. *Бусад холбон зуучлах байгууллагуудын мэдээллийн жагсаалттай байх* – Шаардлагатай үед хохирогч/даван туулагчид мэдээллийн хуудас өгөх.
11. Хохирогч/даван туулагчийн хуваалцаж буй гэмт хэргийн шинжтэй түүхийг үл ойшоох, үл тоомсорлох, дутуу үнэлэх, хүчирхийлэл бүхий үйлдлийг өөгшүүлэн ямар нэгэн интервенц хийхгүй байх
12. Ганцаардуулж, бусдаас холдуулах
13. Бие махбодын хувьд хязгаарлагдмал байдалд оруулах буюу ярилцлагын үед босох, завсарлах, ариун цэврийн өрөө орох зэрэг шаардлагатай хэрэгцээг хангахгүй байх.
14. Уур уцаар, хэт хөөрөл болон өөртөө болон бусдыг түрэмгийлэх гэх мэт бусад хурц мэдрэмжүүдийг шошголж, эмгэг гэж авч үзэх
15. Биеэс шинжилгээ авахдаа зориулалтын бусаар авах, хохирогч/даван туулагчийг бусдын хажууд хувцсаа тайлахыг шаардах
16. Хохирогч/даван туулагчийн бие махбодын болон сэтгэл зүйн хил хязгаарыг үл хүндэтгэх
17. Байгууллагын дүрэм журмыг үйлчлүүлэгчид тулгахдаа тухайн хүнд асуулт асуух, өөрийгөө илэрхийлэх орон зай өгөхгүй байх
18. Байгууллагын чадамжгүй байдал, зохисгүй манлайллыг өөгшүүлэх зэрэг нь хохирогч/даван туулагчдыг дахин сэтгэцийн гэмтэлд оруулах магадлалтай юм.

ХОЁР

СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛД СУУРИЛСАН ХОХИРОГЧ/ДАВАН ТУУЛАГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ БА ТОГТОЛЦОО

2.1

Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/
даван туулагч төвтэй үйлчилгээ
үзүүлэхэд баримтлах зарчим

2.2

Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/
даван туулагч төвтэй үйлчилгээний
онол, арга зүй

2.3

Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/
даван туулагч төвтэй үйлчилгээний
тогтолцоо, хэрэгжүүлэх механизм ба
сайн туршлага

2.1

СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛД СУУРИЛСАН ХОХИРОГЧ/ДАВАН ТУУЛАГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний зорилго нь тухайн тохиолдсон асуудлын үр дагаварт суурилдаг бөгөөд хохирогч/даван туулагч болон мэргэжилтний бие махбод, сэтгэл зүй, танин мэдэхүйн аюулгүй байдал болон хүчирхэгжүүлэх, тэдний давуу байдалд анхаарахад оршино. Олон улсын судалгаануудаас харахад энэ агуулгын хүрээнд ямар үйлчилгээ үзүүлэхэд бус үйлчилгээг “хэрхэн” үзүүлэхэд анхаарах нь зүйтэй гэжээ. Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээ үзүүлэхэд дараах үндсэн 6 зарчмыг баримталдаг¹. Үүнд:

	<p>АЮУЛГҮЙ БАЙДАЛ</p>	<p>Байгууллага, мэргэжилтэн, ажилтнууд нь бүхий л үйл ажиллагаа, үйлчилгээ болон орчин нөхцөлөө үйлчлүүлэгчид тав тухтай, аюулгүй байдлын мэдрэмжийг төрүүлэхүйц байлгах</p>
	<p>ИТГЭЛЦЭЛ БОЛОН ИЛ ТОД БАЙДАЛ</p>	<p>Байгууллага, мэргэжилтнүүд, ажилтнууд болон үйлчлүүлэгч нь үйлчилгээний бүхий л үйл явцад эрх тэгш утга учиртайгаар оролцох</p>
	<p>СОНГОЛТ</p>	<p>Үйлчлүүлэгчдээ үйлчилгээний бүхий л явцад оролцоотой байж, өөрийн саналыг хэлж, сонголт хийх боломжийг бий болгох, үйлчлүүлэгч бүрийн онцгой болон хувь хүний хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээг сонгох</p>
	<p>ХАМТЫН АЖИЛЛАГАА</p>	<p>Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчид хоорондын эрх мэдлийг тэнцвэртэй байлгаж, хамтын ажиллагаатай байх</p>
	<p>ЭРХ МЭДЭЛЖҮҮЛЭХ, ЧАДАВХЖУУЛАХ</p>	<p>Үйлчилгээгээр дамжуулан үйлчлүүлэгчийг эрх мэдэлжүүлэх, чадавхжуулах</p>
	<p>СОЁЛ, ТҮҮХ БОЛОН ЖЕНДЭРИЙН АСУУДАЛ</p>	<p>Үйлчлүүлэгч бүр адил биш тул тухайн үйлчлүүлэгчийн онцлог, эрх, хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээ үзүүлэх</p>

¹ ДСЭМҮЗ-ны Гэмтлийн талаар ойлголт болон гэмтэлд тулгуурласан зөвлөмж. <https://store.samhsa.gov/product/SAMHSA-s-Concept-of-Trauma-and-Guidance-for-a-Trauma-Informed-Approach/SMA14-4884>

1. Аюулгүй байдлыг хангах зарчим

Байгууллага, мэргэжилтэн, ажилтнууд нь бүхий л үйл ажиллагаа, үйлчилгээ болон орчин нөхцөлөө үйлчлүүлэгчид тав тухтай, аюулгүй байдлын мэдрэмжийг төрүүлэхүйц байлгахыг зорино. Үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтнүүд, ажилтнуудын бие махбод болон сэтгэл санааны аюулгүй байдлыг эн тэргүүнд чухалчлан авч үзнэ. Байгууллагын орчин нөхцөл нь үйлчлүүлэгч айдас, аюул мэдрэхгүйгээр харилцах боломжтой, тайван амгалан, хувийн орон зайг чухалчилсан, тавтай суух суудалтай, ус, цай уух боломжтой, ариун цэврийн өрөөтэй, ганцаарчилсан уулзалт зөвлөгөөний өрөөтэй байна. Мөн үйлчлүүлэгч болон мэргэжилтнүүд, ажилтнуудын хоорондын харилцаа, хандлага аль алинд нь аюулгүй байдлыг мэдрүүлсэн буюу хүндэтгэлтэй, итгэлцэлтэй, хамтарсан, үйлчлүүлэгчийн эрхийг хүндэтгэж, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байвал зохино. Мэргэжилтэн, ажилтнууд нь сургалтад хамрагдах, супервишн болон кейс хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр үйлчлүүлэгчид учирч болох эрсдэлийг тооцож, аюулыг бууруулах мэдлэг, ур чадвараа үргэлж нэмэгдүүлэхэд анхаарна.

Хохирогч/даван туулагчдад үзүүлэх нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээний хүрээн дэх бүх шийдвэр, үйл ажиллагаа нь тэдний аюулгүй байдал, өсөж хөгжих эрхэнд халдах ёсгүй төдийгүй бүхий л эрхийг сахин хамгаалахад чиглэнэ. Хохирогч/даван туулагчийн төлөө хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь ойрын болон урт хугацаандаа тэдний бие махбод, сэтгэл санааны сайн сайхан байдлыг хангахуйц байна.

2. Итгэлцэл болон ил тод байдлын зарчим

Байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагаа нь үйлчлүүлэгчид ил тод, нээлттэй байх ёстой бөгөөд үүнийг үйлчилгээ эхлэхээс эхлэн тодорхой тайлбарлаж мэдээллээр хангах нь зүйтэй. Үүнд үйлчилгээний зорилго, үр дүн, үйлчилгээний хувилбарууд, хэрэгжих хугацаа, үйлчилгээний хязгаарлалт буюу үзүүлэх боломжгүй үйлчилгээ, мэргэжилтэн, ажилтны болон үйлчлүүлэгчийн эрх, үүрэг хариуцлагын талаар тодорхой, үнэн шударга мэдээлэл зэрэг багтана.

Байгууллага, мэргэжилтэн, ажилтан нь хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулах, ашиглах, мэдээлэхдээ хууль, журмыг баримтлан нууцыг чанд хадгална. Байгууллага, мэргэжилтэн, ажилтан нь үйлчлүүлэгчтэй итгэлцлийг бий болгох үүднээс нууцлалыг хэрхэн хамгаалах талаараа мэдээлэл өгч, хийж буй үйлдэл, биеэ авч явах байдал, хууль, дүрмийг хэрэгжүүлэх байдлаараа итгэлцлийг улам нэмэгдүүлнэ. Мэргэжилтэн, ажилтан нь үйлчлүүлэгчид үл итгэх, бүрүүтгах, шүүмжлэх, тохуурхах үйлдэл огт хийхгүй бөгөөд үйлчлүүлэгчдээ итгэх, итгэж байгаагаа илэрхийлэх, эргэлзээтэй байдал үүссэн тохиолдолд нөхцөл байдал, баримт материал шаардлагатай бусад зүйлсийг нягтлан авч үзнэ.

3. Сонголттой байх зарчим

Сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалд мэргэжилтэн, ажилтнууд үйлчлүүлэгчдэдээ сонголт хийх боломжийг бий болгож, оролцоотой байхыг санал болгож, үйлчлүүлэгч бүрийн онцгой болон хувь хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийг зоривол зохино. Сэтгэцийн гэмтэлд суурилаагүй, хохирогч/даван туулагч төвтэй биш үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн сэтгэцийн гэмтлийн байдал, хувь хүний онцлог, хэрэгцээг харгалзахгүй, сонголт өгөхгүйгээр үйлчилгээг тулгах, яаруулах, үр дүнд хүрэх гэж хүчлэх эрсдэл үүсгэдэг.

Харин мэргэжилтэн, ажилтнууд нь сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалаар үйлчлүүлэгчид өөрийн асуудлаа хэзээ, хэрхэн шийдэх, ямар үйлчилгээ авах, ямар мэргэжилтэн, ажилтантай хамтран ажиллах зэрэг сонголтыг бий болгосноор үйлчлүүлэгч өөрийгөө болон өөрийн амьдралаа ойлгох, бие махбод, сэтгэл зүй, оюун бодолдоо хяналт тавих, юу хүсэж, түүндээ хэрхэн хүрэхээ шийдэх, өөртөө хариуцлагатай хандах боломж нэмэгддэг. Хохирогч/даван туулагч хүүхдийн амьдралд нөлөөлөхүйц шийдвэр гаргахад хүүхэд өөрөө оролцох, сонголт хийх эрхтэй. Хэр хэмжээнд оролцоотой байх нь хүүхдийн нас, төлөвшил зэргээс хамаарна. Хүүхэд өөрийн эрх, хэрэгцээнд нийцэх боломжгүй сонголт хийх, шийдвэр гаргах тохиолдолд учир шалтгааныг нь хүүхдэд тайлбарлаж өгөх нь зүйтэй.



4. Хамтын ажиллагааны зарчим

Сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалаар байгууллагууд нь үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтэн, ажилтнуудын хоорондын эрх мэдлийг тэнцвэртэй байлгахыг зорих ба хэрэв эрх мэдлийн тэнцвэргүй харьцаа үүсвэл шийдвэрлэх тодорхой арга хэмжээг заавал авна. Мэргэжилтэн, ажилтнууд нь үйлчлүүлэгчтэй бодлоготойгоор, зориудаар хамтран ажиллаж, эрүүл, зохистой харилцааг бий болгож, үйлчилгээг төлөвлөх, шийдвэр гаргах, үнэлэхэд аль аль нь хувь нэмэр оруулж байхад анхаарна.

Байгууллага, мэргэжилтэн, ажилтнууд нь үйлчлүүлэгчтэй хамтран ажиллахгүй, тэднийг идэвх, оролцоогүй халамж хүртэгч байдлаар харж, үйлчилгээгээ тулгавал үйлчлүүлэгчийн хувь хүн, бие даасан байдлыг нь үгүйсгэн, өөрийнх эрхэндээ байлгаж, эрх мэдлээ тогтоож байсан хүчирхийлэл үйлдэгчээс ялгаагүй байдлыг үүсгэнэ. Өөрөөр хэлбэл үйлчилгээгээр дамжуулж үйлчлүүлэгчийг дахин гэмтээх эрсдэлтэй.



5. Эрх зарчим

Үйлчилгээгээр дамжуулан үйлчлүүлэгчийг эрх мэдэлжүүлэх, чадавхжуулах ба асуудлыг даван туулах, өөрөө өөрийнхөө амьдралын эзэн болоход чадавхжуулах аргуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үйлчлүүлэгчийн давуу тал, хүч чадал, нөөц боломж болон эрүүл харилцаа, сайн сайхан зүйлд дасан зохицох, хүнд хэцүү асуудал, эрүүл бус харилцааг даван туулах чадварыг хөгжүүлж, удирдан чиглүүлбэл зохилтой.

Байгууллага, мэргэжилтэн, ажилтнуудын бодит дэмжлэг, үйлчилгээний туслалцаатайгаар хохирогч/даван туулагч өөрийн амьдралдаа хяналт тавих чадвартай болдог. Үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтэн, ажилтнууд нь хохирогч/даван туулагчийг хүчирхийллийг даван туулж, чадавхжихад аюулгүй байдлыг хамгаалж, нөхөн сэргээж, илаарьшихад тусалж, цаашдын зорилго төлөвлөгөөг гаргахад мэдээллээр хангаж, дэмжиж, чиглүүлж байгаа хоёрдогч дүр бөгөөд харин гол эзэн, гол дүр бол хохирогч/даван туулагч өөрөө гэдгийг байнга санаж, баримтлах нь зүйтэй. Ингэснээр хохирогч/даван туулагч нь аливааг хийхэд заавал бусдад найдах, бусдын гарыг харах шаардлагагүйгээр өөрөө шийдэх эрх мэдэл, ур чадвар бий гэдгээ ойлгож чадавхаждаг.



6. Соёл, түүх болон жендэрийн асуудлыг хүндэтгэх зарчим

Байгууллагууд, мэргэжилтнүүд, ажилтнууд нь үндэс, угсаа, шашин шүтлэг, газар зүйн байршил, хүйс, бэлгийн чиг баримжаа болон өөр бусад соёлын хүчин зүйлээс шалтгаалж гарч болзошгүй

ялгаварлан гадуурхалт, ад үзэгдэх байдлын (ухамсартайгаар болон санамсаргүйгээр) талаар мэддэг байх ёстой. Үйлчлүүлэгч бүр нэг адилхан бүлэг биш гэдгийг үйлчилгээний бодлого, үйл явц, практикт тусгаж, хувь хүмүүс болон бүлгүүдийн тусгай хэрэгцээ шаардлагыг үйлчилгээндээ харгалзан авч үзсэн байх нь зүйтэй. Байгууллагууд түүхэн болон үе дамжсан сэтгэцийн гэмтэлтэй холбоотой хэрэгцээ шаардлагад мэдрэмжтэй ханддаг байх ёстой.

Үйлчлүүлэгч бүх хохирогч/даван туулагчид арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, гэр бүлийн нөхцөл байдал, асран хамгаалагчдынх нь байр суурь, соёлын онцлог, санхүүгийн чадавх, мөн онцгой үр чадвартай эсвэл хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран ижил тэгш, чанартай, хүртээмжтэй тусламж үйлчилгээ үзүүлж тэд чадавхжих, өсөн хөгжих бололцоог олгох хэрэгтэй.

2.2

СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛД СУУРИЛСАН ХОХИРОГЧ/ДАВАН ТУУЛАГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОНОЛ, АРГА ЗҮЙ

2.2.1. Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээний онолын үндэс

Сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний онол арга зүй нь хохирогч/даван туулагчид ээлтэй, хүн төвтэй, нийгэм, хамт олон, соёлын олон талт байдлыг авч үзсэн нийгэм, сэтгэл зүйн шинжлэх ухааны онол, үзэл баримтлалд тулгуурлан хөгжсөн байдаг. Энэхүү онол, үзэл баримтлалуудыг танин мэдэж, ойлгосноор сэтгэцийн гэмтэлд суурилсан онол, арга зүйг утга учиртай, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд туслах хамгийн оновчтой арга юу болох, сэтгэцийн гэмтлийн илаарьших үйл явцыг тайлбарласан сэтгэл судлал, гүн ухааны онол хандлагаас дурдвал: харилцан хамаарлын психоанализ, хувь сэтгэл зүй, нийгмийн бүтцийн онол, экологийн болон бүтцийн загвар, үйлчлүүлэгчийн давуу талд тулгуурлах арга, хүмүүнлэгийн сэтгэл зүй, нийгмийн сэтгэл судлалын үзэл баримтлал багтаж байна.²

Харилцан хамаарлын психоанализ (Relational psychoanalysis)

Гринберг, Мичел нар (1983) Фрейдийн сонгодог психоанализ хувь хүний хөгжил төлөвшилд нийгэм, соёлын нөлөөг хэт багаар үнэлж байсныг онцлон тэмдэглэж онолдоо тусгаснаар Харилцан хамаарлын психоанализын үүсэл тавигдсан. Өөрөөр хэлбэл хүүхдийн хөгжилд эргэн тойрны хүмүүсээс хамааралтай (Segalla, 2007) гэдэг ойлголтоор баяжуулсан.

Хувь сэтгэлзүй (Self-psychology)

Хайнз Кохутын 1960-1980 онд боловсруулан хөгжүүлсэн хувь сэтгэл зүйн тухай онол бол нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн психоаналитик онол бөгөөд аливаа сэтгэл зүйн шархыг эдгээхэд чухал нэгэн бүрэлдэхүүн бол итгэлтэй харилцаа бөгөөд түүгээр дамжуулан хувь хүн өөрийн үнэлэмж, зорилго ба үнэт зүйлээ тодорхойлж өөрийн дотоод зохицол нийцэл бий болдог гэдэг санаа юм.

2 Mieseler, V., & Myers, C. (2013). Practical steps to get from trauma aware to trauma informed while creating a healthy, safe, and secure environment for children. Jefferson City: Missouri Coalition for Community Behavioral Healthcare

Нийгмийн бүтцийн онол (Social constructivism)

Нийгмийн бүтцийн онолын гол санаа нь “утга бүтээх” үйл явцын тухай буюу хүн бусад хүмүүстэй болон орчинтой харилцсанаар дотоод ертөнцөө бүтээх танин мэдэхүйн үйл явц өрнөдөг тухай. Өөрөөр хэлбэл хүн бүр өөрийн харах өнцөгтэй бөгөөд тэр хүний ертөнцийг яг тэр өнцгөөс нь харж байж л ойлгох боломжтой (Kelly, 1995). Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд тусламж үзүүлэх гэж байгаа мэргэжилтэн тухайн хүүхдийн нөхцөл байдлыг өөрийнх нь өнцгөөс л харж ойлгож улмаар өөрийгөө эергээр дүрсэлж мэдрэх, бүтээхэд нь дэмжинэ гэсэн үг. Экологийн хандлага (Ecological approach)

Судлаач Пардек (2015)-ын хэлснээр экологийн хандлагаар авч үзвэл үйлчлүүлэгчид тулгараад байгаа асуудал нь тухайн хувь хүний сэтгэлзүйн асуудал гэхээсээ экосистемийн доголдлоос үүдэлтэй буюу хувь хүмүүс, орчноос хамаарахаас гадна өөр хоорондоо түгжин тушсан системээс хамаардаг гэж үздэг. Ялангуяа өсвөр насныхны хувьд хөгжлийн шатны хувьд өөрийгөө таних тодорхойлох дээр үе тэнгийнхэн, гэр бүлээс гадаад орчин дээр гол анхаарал нь төвлөрч байдаг учраас, нөхцөл байдлыг авч үзэхдээ сургууль, үе тэнгийнхэн, хөрш, олон нийтийн сүлжээ гэхчлэн хүрээлэн буй орчин, харилцаа, харилцан хамаарлаар нь харах хэрэгтэй гэсэн байна (Фирмин, 2015).

Давуу талд тулгуурлах арга (Strengths-based practice)

Нөхөн сэргээх үйлчилгээний явцад үүсэж байгаа дэмжлэгт харилцаа бол үйлчилгээг үзүүлэгч, үйлчлүүлэгч хоорондын хамтын ажиллагаа байдаг. Үйлчлүүлэгч зөвхөн хүлээн авах бус тухайн үйлчилгээний явцад өөрийн давуу талаараа хувь нэмрээ оруулдаг. Түүнийг нь дэмжиж оролцоог нь нэмэх нь үйлчилгээний чанарыг ч сайжруулна (Кистарт, 2013). Давуу тал, тэсвэр тэвчээр гэдэг нь “бэрхшээл бартааг даван туулах чадвар, сорилт хямралын дараа эргэн хөл дээрээ босох, сорилтыг хөгжих завшаан болгон ашиглах чадвар” гэж тодорхойлсон байна (Грийнэ ба Лий, 2002). Энэ хандлага сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний бас нэг суурь болдог.

Хүмүүнлэгийн сэтгэл зүй (Humanistic Psychology)

20 дугаар зууны дунд үед гарч ирсэн гешталт, үйлчлүүлэгч төвт, экзистенциал, шийдэлд чиглэсэн товч гэх мэт тодотголтой зөвлөгөө, заслын үйлчилгээний онолын үндсийг Абрахам Маслоу, Карл Рожерс нар тавьсан. Хүн өөрийгөө ойлгодог, ухамсарладаг бөгөөд аливаа сонголтыг өөрийнхөөрөө хийж хариуцлагаа хүлээх чадвартай учраас оюун санаа, зан үйлийн байгаа төлөвийг нь илүү анзааргатай, бодолтой үйлдэхэд нь туслах нь үйлчилгээний гол зорилго байна гэж үздэг (Грийнин, 2006).

Нийгмийн сурган зүй (Social pedagogy)

1844 онд Карл Магерийн нэрлэсэн энэ онол нь аливаа нийгэмд хувь хүний болон ёс суртахууны боловсролыг тайлбарласан. Үүний үндсэн зарчимд: хүүхдийн хөгжлийг дэмжиж бүхэллэг байдлаар харж хандах, үйлчилгээ үзүүлэгч мэдлэг мэргэжлээ дайчлахаас гадна хувь хүнийхээ хувьд чин үнэн харилцааг үүсгэх, тухайн хүүхдийн ертөнцөд нь нэг түвшинд хүрч үйлчлэх, хүүхдийн өдөр тутмын амьдралд нь ойр дөхөм арга, даалгаврыг сонгох, хүүхдийн эрхийг хүндэтгэх, багийн ажиллагааг эрхэмлэх зэрэг багтсан байна (Камерон, Мосс, 2011). Сэтгэцийн гэмтэлд өртсөн хүүхэд асран хамгаалагчид, үе тэнгийнхэн гээд харилцаандаа бэрхшээлтэй байх нь элбэг, түүнд нь зөвлөн чиглүүлэх эерэг харилцааг барьж бий болгоход нь энэ арга чиглэсэн.

2.2.2. Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээний арга зүй

“Сэтгэцийн гэмтэлд суурилсан хөтөлбөр, байгууллага, эсвэл тогтолцоо нь сэтгэцийн гэмтлийн нөлөө их гэдгийг ухамсарлаж, илаарьшуулах боломжит арга замыг ойлгодог, үйлчлүүлэгчид, гэр бүл, ажилтнууд болон тухайн системтэй хамааралтай бусад хүмүүст илэрч гарах шинж тэмдгийг таньж мэддэг, сэтгэцийн гэмтлийн тухай мэдлэгийг бодлого, журам, үйл ажиллагаанд бүрэн тусган оруулж, дахин гэмтэлд өртүүлэхгүй байхын тулд ажилладаг”.

Донтолт болон сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний захиргаа “Гэмтлийн талаарх ойлголт болон гэмтэлд тулгуурласан зөвлөмж”

Дараахаас үзэж болно: <https://store.samhsa.gov/product/SAMHSA-s-Concept-of-Trauma-and-Guidance-for-a-Trauma-Informed-Approach/SMA14-4884>

Сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалын талаар олон тодорхойлолт байдаг ба эдгээрээс АНУ дахь Донтолт болон Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний Захиргааны тодорхойлолтыг оруулав. Бүх ажилтнууд (үйлчилгээний болон захиргааны ажилтан эсэхээс үл хамааран) сэтгэцийн гэмтлийн талаар анхан шатны ойлголт мэдлэгтэй байх нь сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалын үндсэн суурь юм³. Зарим ажилтнууд илүү өндөр түвшний сургалтад суух шаардлагатай байж болох юм. Жишээ нь нийгмийн ажилтнууд, цагдаагийн алба хаагч, эмнэлгийн эмч, ажилтнууд өөрсдийн үүрэгтэй холбоотой сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалыг суралцаж, захиргааны ажилтнууд үндсэн ойлголт, нийтлэг шинж тэмдгийн талаар суралцаж болох юм. Гэхдээ бүх ажилтнууд сэтгэцийн гэмтэл, гарах үр дагаврын талаар наад захын анхан шатны ойлголттой байх нь тун чухал юм. Үүнийг үр дүнтэй манлайлал, ажилтнуудын сургалт болон ажилтнуудыг дэмжих бодлого, үйл явц болон гарын авлагаар дамжуулан бий болгож, сайжруулж болно.

Сэтгэцийн гэмтэл янз бүрийн байдлаар илэрдэг болохыг үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтэн, ажилтнуудад ойлгуулснаар үйлчлүүлэгчийн сэтгэл зүй, харилцаа, хандлага, зан үйл, нөхцөл байдал зэрэгт шүүмжлэлтэй хандахгүй байхад тусална. Мөн үйлчлүүлэгчийг асуудлаа шийдэхэд нь хэрхэн туслах болоод дахин гэмтэлд өртөхөөс нь сэргийлэх талаар мэргэжилтэн, ажилтнуудын мэдлэг, арга зүй, ур чадварыг хөгжүүлэхэд тусалж чадна.

Байгууллага нь сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээг хэрэгжүүлэхийн тулд бодлого, харилцааны соёлдоо дараах зүйлсийг тусгавал зохино. Үүнд:

1. Тухайн байгууллагын бүхий л мэргэжилтнүүд, ажилтнууд сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний талаар байнга суралцаж байх. Сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний зарчим, аргачлал нь байгууллагын үйлчилгээний соёл байх ёстой ба тогтмол мэргэжил дээшлүүлж, чадвараа нэмэгдүүлж байх.
2. Бүх мэргэжилтэн, ажилтнууд (захиргааны, цагийн ажилтан, сайн дурын ажилтан гэх мэт) сэтгэцийн гэмтлийг танин мэдэж, ойлгож, шаардлагатай арга хэмжээг авч бүгд адил хариуцлага хүлээх.
3. Бүх мэргэжилтэн, ажилтнууд (захиргааны, цагийн ажилтан, сайн дурын ажилтан гэх мэт) сэтгэцийн гэмтлийн талаар анхан шатны сургалтад хамрагдаж хохирогч/даван туулагчийн сэтгэцэд дахин гэмтэл учрахаас ямагт сэргийлэх.

³ Донтолт болон сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний захиргаа. Гэмтлийн талаар ойлголт болон гэмтэлд тулгуурласан зөвлөмж. Дараахаас үзэж болно: <https://store.samhsa.gov/product/SAMHSA-s-Concept-of-Trauma-and-Guidance-for-a-Trauma-Informed-Approach/SMA14-4884>

4. Бүх ажилтнууд мэргэжлийн ёс зүй, тэр дундаа сэтгэцийн гэмтэлд суурилсан хувийн болон мэргэжлийн хил хязгаарыг баримтална. Мөн үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах, ялгаатай байдлыг хүндлэх гэх зэрэг мэргэжлийн ёс зүйн наад захын зарчмыг баримтлахаас гадна хүн бүрийн даван туулах арга өөр байдагт мэдрэг байж хүндэтгэлтэй хандах.
5. Ажилтнууд өөрийн сэтгэл зүйн болон бие махбодын эрүүл мэндэд байнга анхаарах. Мэргэжилтний сэтгэцийн дам гэмтэл (vicarious trauma), эрсдэлийн менежментийн талаар ойлголттой байж өөрийгөө хамгаалах, мэргэжилтнүүдийн зөвлөлдөх уулзалтыг тогтмол зохион байгуулах, хамрагдах. Ажилтнуудад байгууллагын хөтөлбөр тохиромжгүй, хүртээмжгүй, аюултай байвал үйлчлүүлэгчдэд мөн адил байна гэдгийг ойлгох.

Сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний арга барилыг нэвтрүүлэх нь ямар нэгэн тодорхой техник, хяналтын хуудсаар дамжин хийгддэггүй. Энэ нь байгууллагын түвшинд эерэг соёлын өөрчлөлт бий болгох ба байнгын анхаарал, халамж, ухамсар, мэдрэмжийг шаарддаг.

Байгууллага нь сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээг үзүүлэхдээ дараах алхмуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

Алхам 1: Хохирогч/даван туулагчид үзүүлэх албан болон албан бус үйл ажиллагаа, үйлчилгээг тодорхойлоорой.

- Үйлчилгээний төлөвлөгөө, үйлчилгээний зураглал гаргах,
- Төлөвлөгөө, зураглалын дагуу үйлчилгээ тус бүрд аль мэргэжилтэн ажиллах, ямар үүрэг хариуцлага хүлээхийг тодорхойлох,
- Үйлчилгээний орчин, нөхцөлийг урьдчилан тодорхой болгож, тохижуулах – хүлээн авах, хүлээлгийн өрөө, албан тасалгаа гэх мэт.

Алхам 2: Үйл ажиллагаа, үйлчилгээг хариуцан ажиллаж буй мэргэжилтэн, ажилтнаас үйлчилгээний явц, нөхцөл байдал ямар байгааг тодруулж, мэдээлэл авч байгаарай.

- Тухайн үйл ажиллагаа, үйлчилгээг хариуцан ажиллаж буй мэргэжилтэн, ажилтнаас хохирогч/даван туулагчийн нөхцөл байдал (нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн үнэлгээ) болон үйлчилгээ хэрхэн, ямар шатандаа явагдаж байгаа (үйлчилгээний явцын мэдээлэл, үнэлгээ) ямар үр дүнд хүрсэн талаар мэдээлэл авч, тодорхойлох,
- Сэтгэцийн гэмтэлд суурилсан зарчмын дагуу хохирогч/даван туулагчийн аюулгүй байдлыг хангаж, итгэлцлийг бий болгож, сонголттой, оролцоотой, чадавхжуулсан, онцлогийг харгалзсан үйлчилгээг үзүүлж байгаа эсэхийн талаар мэргэжилтэн, ажилтнаас мэдээлэл авах.

Алхам 3: Дараах жагсаалтаар үйлчилгээний үнэлгээ, сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээг хөгжүүлэхэд анхаараарай.

- Боломж – Ямар зорилгуудад хүрэх боломжтой вэ?
- Нөөцүүд – Зорилгодоо хүрэхэд санхүү, хүний нөөц, бусад шаардлагатай нөөцүүд байна уу?
- Тогтолцооны дэмжлэг – Зорилгоо биелүүлэхэд хууль эрх зүй, санхүү, хамтын ажиллагааны үр нөлөөтэй, өргөн хүрээтэй дэмжлэг хэрхэн авч чадах вэ?
- Урт хугацааны үр дүн – Зорилгуудын аль нь удаан хугацааны үр дүнтэй вэ?
- Чанартай үр дүн – Зорилгуудын аль нь үйлчлүүлэгчийн амьдралд бодит өөрчлөлт бий болгож чадах вэ?
- Эрсдэл ба үр дүнгүй байх – Үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн амьдралд сөргөөр нөлөөлөх эсвэл үр дүнгүй байх эрсдэл байна уу?

Боломж	Нөөцүүд	Тогтолцооны дэмжлэг	Урт хугацааны үр дүн	Чанартай үр дүн	Эрсдэл ба үр дүнгүй байх
Ямар зорилгод хүрэх боломжтой вэ?	Зорилгодоо хүрэхэд санхүү, хүний нөөц, бусад шаардлагатай нөөцүүд байна уу?	Зорилгоо биелүүлэхэд хууль эрх зүй, санхүү, хамтын ажиллагааны үр нөлөөтэй, өргөн хүрээтэй дэмжлэг хэрхэн авч чадах вэ?	Зорилгын аль нь удаан хугацааны үр дүнтэй вэ?	Зорилгын аль нь үйлчлүүлэгчийн амьдралд бодит өөрчлөлт бий болгож чадах вэ?	Үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн амьдралд сөргөөр нөлөөлөх эсвэл үр дүнгүй байх эрсдэл байна уу?
Жишээ					
Үйлчлүүлэгч нь үйлчилгээний төрөл болон үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтнийг сонгох	Олон төрлийн үйлчилгээг мэргэжлийн байгууллагуудтай гэрээлэн гүйцэтгэх	Хүүхэд хамгааллын төсөв нэмэгдэж, зарцуулалт уян хатан болсон	Мэргэжлийн үйлчилгээ хөгжинө. Сэтгэцийн гэмтэлд суурилагүй үйлчилгээ үзүүлдэг байгууллага, мэргэжилтнүүд хумигдана.	Үйлчлүүлэгч өөрт ээлтэй үйлчилгээг сонгон үйлчлүүлснээр хүчирхийллийг даван туулах чадавхжих процесс сайжирна.	Үйлчилгээ үзүүлэгч байгууллага, мэргэжилтнүүд эргэх холбоотой, уялдаатай ажиллахгүй бол үйлчлүүлэгч завсарт нь орхигдох, үйлчилгээ салангид болох эрсдэлтэй.

Алхам 4: Зорилтоо тодорхой болгох, мэргэжилтэн хариуцлагатай байх

- Үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтэн, ажилтны үүрэг хариуцлагыг үнэлж, мэргэжлийн түвшинд, үр дүнтэй ажиллаж байвал үүнийгээ хадгалж ажиллах, үр дүнгүй ажиллаж байвал сайжруулах, хариуцлагатай хандахыг зөвлөж, дэмжих.
- Үйлчилгээний явцын байдал, үйлчлүүлэгчийн нөхцөл байдлын өөрчлөлтийг үнэлэн үйлчилгээний зорилго, зорилтуудаа дахин тодорхойлж, үйлчилгээ үзүүлэх хугацаа, хүрэх үр дүнгээ дахин тодорхойлох.

Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээний арга зүй

Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагчид ээлтэй үйлчилгээг үзүүлэх арга зүйг хэрэгжүүлэхийн тулд мэргэжилтнүүд юун түрүүнд сэтгэцийн гэмтлийн талаар мэдээлэл, ойлголттой байх хэрэгтэй. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс гаргасан **“Хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: Өмгөөлөгчдөд зориулсан гарын**

АНУ-ын Аляска мужийн хамгаалах байрны дотоод журмын нууцлалыг хамгаалах хэсгээс...

Хамгаалах байрны менежер нь ажилтнууд болон сайн дурын ажилтан бүртэй нууцлалын гэрээг байгуулж, ажилтны хүний нөөцийн баримт бичигт хавсаргана. Нууцлалын гэрээг зөрчих нь ажлаас халагдах үндэслэл болно. Ажилтан нь үйлчлүүлэгчтэй олон нийтийн газар таарах бол түүнийг таньдаг талаар мэдэгдэж болохгүй бөгөөд түрүүлж мэндэлж болохгүй. Үйлчлүүлэгч нь ажилтантай эхэлж харилцсан тохиолдолд мэнд ба үйлчилгээний талаар бусдад сонсогдох, мэдэгдэхээр ярилцаж болохгүй.

ANDVSA; Materials from New Beginnings for Battered Women and Their Children, Training Manual, 2000

авлага"-аас хууль, журмуудтай танилцаж, даган мөрдөхийг санал болгож байгаа бөгөөд мэргэжилтнүүд Сэтгэцийн гэмтэлд суурилсан зарчмуудыг баримтлан ажиллана. Үүнийг өмнөх бүлгээс үзэх боломжтой.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь орчин, нөхцөлөө хохирогч/даван туулагчид ээлтэй, аюулгүй байлгах

1. **Ээлтэй, аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх:** Хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн орчин нөхцөл нь Монгол Улсын стандарт MNS 6040:2019 "Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага"-д заасны дагуу байх ба ялангуяа ганцаарчилсан зөвлөгөөний өрөө дуу тусгаарлалттай, орчны элдэв дуу чимээ, хөдөлгөөнөөс хол, бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхэд сэтгэл зүйч, нийгмийн ажилтантай ярилцахад саад учруулахгүйгээр зохион байгуулах,
2. **Аюулгүй байдлыг мэдрүүлэх:** Бэлгийн хүчирхийллийн улмаас хохирогч/даван туулагч нь сэтгэцийн гэмтэлд орж, байнга аюулыг мэдэрч, түүнээс үүдэлтэйгээр бие махбод, сэтгэл зүй, оюун санаанд сөрөг шинж тэмдгүүд илэрдэг. Иймд үйлчилгээний мэргэжилтэн, ажилтнууд нь хохирогч/даван туулагч хүүхдэд аюулгүй газар байгаа гэдгийг сануулж хэлэх, орчноо танилцуулах, дасан зохицоход нь туслах,
3. **Хохирогч/даван туулагчийг айлгасан, таагүй сэтгэгдэл төрүүлсэн багаж тоног төхөөрөмж байлгахгүй байх:** Зарим нэг цэгийн үйлчилгээний төвүүд нь цагдаа, эмнэлгийн байгууллагын харьяа буюу дэргэд нь байдаг онцлогоос шалтгаалан эмнэлгийн ор, багаж хэрэгсэл, цагдаагийн байгууллагын хэрэгслүүд байдаг. Эдгээр нь хохирогч/даван туулагчийг айлгах, тавгүй байдалд оруулах, орчиндоо дасахад саад учруулах эрсдэлтэйг харгалзан хохирогч/даван туулагч байрлах өрөөнүүд болох унтлагын, амралтын, зөвлөгөөний өрөө зэрэгт эмнэлэг, цагдаагийн багаж, хэрэгслүүдийг байлгахгүй байхад анхаарах,
4. **Аюултай зүйлсийг хүүхдээс хол байлгах:** Эмийн сан, ариутгалын болон цэвэрлэгээний бусад аюултай бодис, бүтээгдэхүүнүүдийг хохирогч/даван туулагч хүүхдээс хол, цоожтой, аюулгүй газар байрлуулж, хүүхэд санаатай болон санамсаргүйгээр хэрэглэх, гэмтэж бэртэх, хордохоос урьдчилан сэргийлэх.

2.2.2. Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээний арга зүй

Бүлгийн зөвлөгөө, үйлчилгээнд саналаар нь оролцуулах: Бусад үйлчлүүлэгчтэй хамтдаа оролцох бүлгийн үйлчилгээг бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхдэд тайлбарлаж, танилцуулсны дараа өөрийнх нь саналаар буюу сайн дурын байдлаар оролцуулах, заавал оролцуулах гэж албадахгүй байх;

Зөвлөгөө, үйлчилгээг хүүхдийн нас, сэтгэхүй, бусад онцлог байдалд нь тохируулах: Бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхдийн нас, сэтгэхүй, хэл ярианы зэрэг онцлогт тохируулах, ярихыг тулгах, байнга асуулт асууж залхаахаас илүүтэй чөлөөтэй байлгах, тоглуулах, зуруулах, дасгал хөдөлгөөн хийлгэх гэх зэргээр өөрөөр нь байлгах. Хохирогч/даван туулагч хүүхдийн үгээр, ойлгогдох байдлаар ярих. Хэрэв ойлгохгүй бол энэ үгийг, энэ зүйлийг чи эсвэл танай нутагт юу гэж хэлдэг вэ? гэх зэргээр асууж, ойлголцох. (Бага насны хүүхэд эд эрхтэн ялангуяа нөхөн үржихүйн эрхтнүүдийг гэрийнхнийхээ зааснаар нэрлэдэг. Жишээ нь: бэлэг эрхтэнг боожгой, шувуу гэх мэт)

Одоо цагт төвлөрүүлэх: Сэтгэцийн гэмтэлтэй холбоотой зүйлийг ярьсан, хөндсөн бол заавал одоо цагт төвлөрүүлж, газардуулах техникийг ашиглаж, аюулгүй орчинд, аюулгүй цаг хугацаанд байгааг ойлгуулах;

Үйлчилгээгээр дамжуулж дахин сэтгэцийн гэмтэлд оруулахаас хатуу зайлсхийх: Үйлчлүүлэгч хүсээгүй үед хуулийн байгууллага, мөрдөн байцаагчийн шахалтаар бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхдээс мэдүүлэг авах, бэлэн биш үед нь шахах, сүрдүүлэх байдлаар харьцахгүй байх, болсон үйл явдлыг заавал ярихыг шахаж, шаардахгүй байх;

Хохирогч/даван туулагч хүүхэд бэлэн биш ч мэдүүлэг авах зайлшгүй тохиолдолд дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Хүүхдийг тусгайлсан, тайван, аюулгүй орчинд асран хамгаалагч эсвэл итгэлцэл үүссэн хүнтэй хэсэг хугацаанд байлгаж орчинд нь дасгах.
- Сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нь хүүхдэд хямралын үеийн зөвлөгөө үзүүлж, тайвшруулж, газардуулсан байх.
- Мэдүүлэг авч буй алба хаагч нь хүүхэдтэй ижил хүйсийн эсвэл хүчирхийлэл үйлдэгчээс өөр хүйсийн хүн байх.
- Хүүхдийн нас, сэтгэхүй бусад онцлогт тохирсон хэрэгслүүд болох зураг, баримал, зурагт карт, тоглоом зэрэг ашиглан ярилцах
- Мэдүүлэг авах албан хаагч тайван, хүндэтгэлтэй, ажигч гярхай, мэдрэмжтэй байж, хүүхдийн хариу үйлдэлд хянамгай хандан ярилцлагыг өрнүүлэх.
- Хүүхэд мэдүүлгийн үед паникт орох буюу гар хөл нь чичирч салганах, ухаан балартах, зүрх дэлсэх, гэдэс, ходоод, давсаг нь хямрах зэрэг шинжүүд илэрвэл мэдүүлгийг шууд зогсоож эрүүл мэндийн тусламж үзүүлэх. Хүүхэд тайвширсны дараа мэдүүлгийг үргэлжлүүлэх.

Зөвшөөрөл авах: Тэмдэглэл бичих, зураг авах, дүрс болон дуу бичлэг хийх, өөр хэлбэрээр баримтжуулалт хийх бол зорилгыг хэлэх, бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхэд түүний хууль ёсны асран хамгаалагчаас заавал бичгээр зөвшөөрөл авах;

Албадахгүй байх: Эмчид үзүүлэх ялангуяа нөхөн үржихүйн үзлэг, оношилгоо хийх гэж байгаа бол сайн тайлбарлах, айдас, түгшүүрийг бууруулсны дараа хийх. Бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхэд хүсээгүй, зөвшөөрөөгүй, бэлэн биш бол албадахгүй байх. Үүний оронд сонголт өгөөрэй. Жишээ нь “Дараа үзүүлэх үү?”, “Түр хүлээх үү?”, “Ариун цэврийн өрөө ормоор байна уу?”, “Эхлээд цай уух уу?” гэх зэргээр өөрийнх нь саналыг асуух, хохирогч/даван туулагч хүүхдийн айдас, түгшүүр нь буурсны дараа эмчийн үзлэгийг хийх;

Итгэлцлийг бий болгох: Бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхдэд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нь итгэж байгаагаа илэрхийлэх, түүнд юу хийж өгч чадах, юуг чадахгүй гэдгээ тодорхой хэлэх, нууцыг нь хэрхэн хадгалж, хамгаалахаа хэлэх зэргээр итгэлцэл бүхий харилцааг бий болгох;

Онцгойлохгүй, нэр шошго зүүхгүй, ялгаварлахгүй байх: Бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхдийг бусад үйлчлүүлэгчээс онцгойлон маш их санаа тавих эсвэл хайхрахгүй орхихоос зайлсхийх. “Бэлгийн хүчирхийллийн хохирогч” гэсэн үг хэллэг, үйлдэл гаргаж ялгаварлахгүй байж, бусад үйлчлүүлэгчтэй адилхан энгийн, хүндэтгэлтэй харилцах;

Сэтгэл зүйн боловсрол олгох: Бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхдийн онцлог, хэрэгцээ, нөхцөл байдалд тохирсон, түүнд шаардлагатай асуудлуудаар сэтгэл зүйн боловсрол олгон чадавхжуулах.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхэдтэй харилцах арга зүй (байцаалт авах, үнэлгээ хийх, ярилцах гэх мэт)

Чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд харилцааны ур чадвар хамгийн чухал. Хүүхэд бэлгийн хүчирхийллийн тухай ярихад хариуд нь үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн юу гэж хэлсэн, яаж хэлсэн бэ? гэдэг нь хүүхдийн илаарьших үйл явцад шууд нөлөөтэй болох нь нотлогдсон байдаг. Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн хувьд үзэж туулсан зүйлээ хүмүүст ярихад туйлын хэцүү байх талтай. Зарим хүүхдийн хувьд насанд хүрэгчдэд, ялангуяа сайн танихгүй хүнд итгэхэд хэцүү байдаг. Жишээ нь: юм ярихгүй байх, асуулт асуухад орилж хашхирах гэх мэтчилэн эсэргүүцэж магадгүй. Иймд хүүхэдтэй харилцахдаа дараах аргуудыг ашиглаарай.

Хүүхэдтэй ярилцахаас өмнө бэлдэх: Хүүхдийн насанд тохируулан хэрхэн ярилцах, ямар асуулт асуух талаараа төлөвлөвөл хялбар байх болно. Ярилцлага эхлэхээс өмнө ярилцлагын зорилго, ямар зүйлийг хамран ярилцах талаараа жагсаан бичээд үүний хүрээндээ хүүхдийн нас, онцлогт тохирсон үг өгүүлбэрээр асуултаа зохиогоорой. Ярилцлагын үеэр ямар хүмүүс хамт байх, ярилцлагаа хэрхэн баримтжуулахаа тооцоолж суудлын байршил, камер, дуу хураагуур зэргийг бэлдэх.

Дэмжиж урамшуулах: Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд өөрөө туслалцаа хүсэж ирэх нь ховор бөгөөд ихэвчлэн асран хамгаалагч, насанд хүрсэн хүн түрүүлж ханддаг. Хүүхэд өөрт нь юу тохиолдсоныг ойлгохгүй, эсвэл айж ичсэнээсээ болоод тантай ярилцахгүй байж болно. Таны анхны хариу үйлдэл ямар байгаагаас хүүхдэд аюулгүйн мэдрэмж төрөх, ярих сэдэл үүсэх зэрэг шалтгаалах бөгөөд цаашдын сэтгэл зүйд эерэг нөлөө үзүүлэх болно. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эерэг, дэмжсэн хариу үйлдэл таатай мэдрэмж төрүүлэх бол сөрөг (хүүхдэд итгэхгүй байх, хүүхэд рүү уурлах гэх мэт) хариу нь тэдний сэтгэл зүйн гэмтлийг сэдрээж дахин гэмтээдэг.

Бататган сануулах: Болж өнгөрсөн зүйлд хүүхэд ямар ч буруугүй бөгөөд хэлсэн үгэнд нь итгэж байгаа гэдгээ бататгаж сануулах хэрэгтэй. Хүүхдүүд бэлгийн хүчирхийллийн талаар худлаа хэлэх нь нэн ховор учраас өөрт нь юу тохиолдсон талаар ярихад нь дэмжиж зоригжуулахад бүх анхаарлаа хандуулаарай. “Би чамд итгэж байна”, “Энэ чиний буруу биш” гэх мэт тайвшруулах үгийг эхний уулзалтын явцад болон үйлчилгээний турш хэлж байгаарай.

Гэм хор учруулахгүй байх: Хүүхдийг нэмж цочролд оруулахаас болгоомжил. Үүний тулд доорх үйлдлийг гаргахгүй байх хэрэгтэй:

- Хүүхдэд уурлах, уцаарлах
- Хариулахад бэлэн биш байхад нь асуултад хариу авах гэж хүчлэх, давтан асуух
- Ярилцахад бэлэн болоогүй байхад нь бэлгийн хүчирхийллийн талаар яриулах гэж хүчлэх
- Хүчирхийллийн талаар олон хүнд, давтан давтан яриулах

Хүүхдэд дарамт учруулах үйл ажиллагаа, харилцааг хязгаарлаж хориглохыг хичээх хэрэгтэй.

Хүүхдэд ойлгогдохоор ярих: Чадах чинээгээрээ хүүхдэд тохируулж харилцаарай. Хүүхдийн нас, сэтгэхүй, өсөлт хөгжлийн онцлогт нь тохируулан тэдэнд ойлгогдохоор ярьж тайлбарлаарай.

Хүүхдийг аюулгүй, тухтай байхад нь туслах: Дуу чимээг маш сайн тусгаарласан орчинд ярилцаарай. Хүүхэдтэй ярилцаж байх хооронд хүүхдийн итгэлтэй насанд хүрэгчийг нь хамт байлцуулж (эсвэл байлгахгүй) болно гэдгийг хүүхдэд хэлнэ. Хүүхдийг яриулах гэж хүчилж болохгүй, мөн сайн итгэхгүй байгаа хүнийх нь хажууд ярихыг тулгаж болохгүй. Хүүхдийг хүчирхийлсэн байж болзошгүй сэжигтэнг хүүхэдтэй ярилцах үедээ байлцуулж болохгүй. Хүүхдэд ямагт үнэнийг хэлэх хэрэгтэй, хэдий амаргүй байсан ч гэсэн үнэнийг л хэлнэ. Хэрвээ та асуултад нь хариулж мэдэхгүй байгаа бол “Би мэдэхгүй байна” гэж хэлж болно. Шударга, нээлттэй байснаар хүүхдэд итгэлтэй, аюулгүй харилцаа тогтоно.

Хүүхдэд яагаад ярилцаж байгаагаа хэлэх: Хохирогч/даван туулагч хүүхэдтэй уулзах бүрдээ тухайн уулзалтын зорилгыг хүүхдэд тайлбарлахад цаг гаргаарай. Хүүхэдтэй уулзаж, ярилцаж байгаагийн шалтгаан, хүүхэд болон асран хамгаалагчаас ямар асуулт асуух талаар тайлбарлах нь чухал. Хийж байгаа зүйлээ алхам тутамд энэ нь өөрт нь хэрхэн тусалж, аюулгүй тайван байхад нь дэм болох вэ гэдгийг тайлбарлаарай.

Үгэн бус харилцаа буюу биеийн хэлэмжийг анхаарах: Хүүхдийн болоод өөрийнхөө үгэн бус харилцаа, илэрхийллийг анзаарч байх нь чухал. Хүүхдүүд өөрт нь тавгүй байгаагаа уйлах, чичрэх, нүүрээ нуух, бусад биеийн хэлэмжээрээ илэрхийлдэг. Насанд хүрэгчид ч мөн үгэн бус байдлаар харилцдаг. Хэрэв та биеэ барьсан, хүүхдийн ярьж буй зүйлийг сонирхохгүй байгаа юм шиг харагдвал хүүхэд түүнийг буруугаар ойлгож, түүнээсээ болоод итгэл алдрах, ярих хүсэлгүй болох хүртэл нөлөөлж болзошгүй.

Хүүхдийн бодол санаа, итгэл үнэмшлийг нь дагах: Хүүхэд өөрт нь юу тохиолдсон тухай мөн түүний өмнөөс шийдэж хийж байгаа зүйлсийн талаарх санал бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх эрхтэй. Та хүүхдийн тэр эрхийг нь, өөрөөр хэлбэл санаа бодлоо илэрхийлэх (эс илэрхийлэх) эрхийг нь хүндэтгэж харилцах үүрэгтэй. Хүүхэд харилцааны явцад юу болохыг шийдэх эрхтэй гэдгийг хүүхдэд мэдрүүлэхийг хичээх хэрэгтэй. Хүүхэд “Мэдэхгүй” гэж хариулах юм уу огт ярихаа больж болно.

Чадахгүй зүйлээ амлахгүй байх: Хүүхэд аль хэдийн ойр дотнын хэн нэг хүндээ итгэх итгэл нь алдарчихсан байх талтай. Иймд танд итгэж болно гэж батлах нь маш чухал боловч өөрийнх нь танд хэлсэн зүйлийн зарим хэсгийг нь задруулах хэрэгтэй бөгөөд тэгж байж л өөрийг нь хамгаалж, аюулгүй байлгах боломжтой гэдгийг мэдэгдэх нь чухал. Хэрэв хүүхэд өөрт нь аюултай, гэм хор учруулсан зүйлийн талаар яривал түүнийг нууцалж хадгалж чадахгүй бөгөөд бусад шаардлагатай хүмүүст мэдэгдэх ёстой болохыг хэлж тайлбарлаарай.

Үгэн харилцааны аргууд хэрэглэх: Зарим хүүхэд өөрт тохиолдсон, мэдэрсэн зүйлээ эсвэл өөр чухал зүйлийг дүрсэлж илэрхийлэхэд тохирох үгийг олохгүй байж болно. Хүүхдийн нас, өсөлт хөгжлийн онцлогоос хамааран харилцаанд дэмжлэг үзүүлэх олон төрлийн аргыг хэрэглэж болно. Зургаа ба түүнээс дээш насны үг хэллэг, яриагаар өөрийгөө илэрхийлэх чадвартай хүүхдүүдэд дараах аргуудыг ашиглаж болно.

- Эхлээд энгийн асуулт асуух – Шүүд хүчирхийллийн талаар асуухыг урьтал болгохгүй өдөр тутмын амьдрал, сургууль, гэр бүл гэх мэт ердийн зүйлс асууж ярилцана. Тэгснээр хүүхдийн ярианы чадварыг баримжаалах бөгөөд хүүхэд танд дасахад нь тус болно.
- Аль болох нээлттэй асуултуудыг ашиглах – Хүүхдийг төөрөлдүүлж, буруу хариулахад хүргэж болзошгүй олон сонголттой эсвэл зөвхөн тийм/үгүй гэсэн хаалттай хариулт өгөхүйц асуултуудаас зайлсхийх.
- “Яагаад”, “Яах гэж” гэдэг асуултыг хэрэглэхгүй байх – Ийм асуултын хариулт нь хүүхдэд ч,

танд ч мухардмал мэдрэмж төрүүлдэг (Жишээ нь: “мэдэхгүй”, мөрөө хавчих, чимээгүй болох гэх мэт). Мөн “Яагаад” гэдэг асуулт “Яагаад тэгээгүй...” гэдэг асуултууд хүүхдийг буруутгаж байгаатай адил ойлгогддог болохыг санаарай. Түүний оронд аливаа зүйлийн талаар юу гэж бодож байгааг нь асуух. (Жишээ нь: “Ямар шалтгаантай... гэж чи бодож байна вэ?”).

- Хүүхдийг үргэлжлүүлэн ярихыг нь дэмжиж, урамшуулах үгсийг хэлэх – Жишээлбэл “.....-ны тухай нэмж ярьж өгөөч”, “.....гэдгээрээ юуг хэлсэн бэ”, “... дээр жишээ хэлж өгөөч”, “...тэгээд дараа нь юу болсон бэ?”
- Хүүхдийн өмнөөс нь ярихгүй байх – Үгэн ба үгэн бус харилцаанд алинд нь ч хүүхдийн өмнөөс ярихаас болгоомжлох хэрэгтэй. Жишээлбэл: хүүхдэд биеийнх нь хаана хүрснийг асуух тохиолдолд “Гараа чиний хөхөн дээр тавьсан уу?”, эсвэл хүүхэдтэй ярилцахдаа ашиглаж байгаа тохиолдолд хүүхэлдэйнхээ хөх рүү заагаад “Чиний энд чинь хүрсэн үү?” зэргээр чиглүүлэхийг оролдож болохгүй. Харин түүний оронд дараах асуултуудыг ашиглаарай:
 - “Чамд хүн нэг л эвгүйцмээр юм уу, аймаар ч юм шиг санагдахаар хүрч байсан уу?”
 - “Чамд яаж хүрсэн тухай чи надад хүүхэлдэйн дээр үзүүлж эсвэл хэлж болох уу?”
 - “Дараа нь юу болсон талаар ярилцаж болох уу?”
 - “Өөрийнхөө үгээр хэлээд үзвэл чамд ямар санагдаж байна вэ?”

Үгээ зөв сонгох: Хүүхдүүд, ялангуяа зургаан наснаас доош насны хүүхдүүд үгийг шууд утгаар нь ойлгодог учраас маш тодорхой тухайлсан үгийг сонгож, ярих хэрэгтэй. Бага насны хүүхдийн хэл яриа болон логик сэтгэлгээ гүйцэд хөгжөөгүй байдаг тул ярилцаж байх үед хүүхэд таны хэлж буй үгийг ойлгож байгаа эсэхийг анзаарах, лавлаж асуух ба хэрэв ойлгоогүй бол үгийн утгыг тайлбарлаж дахин хэлж өгнө. Жишээлбэл: та хүүхдээс “Чамайг машиндаа суулгаад авч явсан уу?” гэж асуухад хэрэв тэр суулгасан машин нь ачааны машин байсан бол таны асуултад “Үгүй” гэж хариулж магадгүй. Тиймээс “чамайг юунд суулгаж явсан бэ? хэрэв чи хэлж мэдэхгүй байвал дүрсэлж зурж үзүүлэх үү? эсвэл дахиад дэлгэрүүлж хэлэх үү? гэх мэтээр ярилцана.

Хүүхдийг дэмжиж, бататгах: Хүүхэд танд болсон явдлын тухай ярьсны дараа “Энэ зүйлийг ярихад чамд ямар байсан бэ, ярихад хэцүү эсвэл ярьмааргүй санагдаж байсан ч чи ярьж чадлаа. Чиний надад ярьсан нь зөв зүйл боллоо. Чи ярьж байж бид тэр муухай хүнээс чамайг болон бусад хүүхдүүдийг хамгаална.” гэх зэргээр ярьсан нь зөв байсныг бататгаж ойлгуулна. Ингэснээр хүүхэд санаа, шийдлээ эргэж харах боломж бий болдог.

Үгэн бус харилцааны аргууд хэрэглэх: Бага насны хүүхдүүд эсвэл үг яриагаар харилцахад үр дүн тааруу байгаа хүүхдүүдтэй тоглоом болон хэрэглэгдэхүүн ашиглан харилцах арга үр өгөөжтэй юм. Хэрэглэгдэхүүнд урлагийн сэтгэл заслын аргууд буюу зурах, дүрс хайчлан наамал, баримлын шавар, тоглоом, хуруун хүүхэлдэй гэх зэргийг ашиглан хүүхэдтэй харилцаж болно. Ингэхдээ шууд болон шууд бус хоёр хэлбэрээр ашиглаж болно.

Шууд бус арга – Шууд бус арга нь хүүхдийг зураг зурах, наамал, баримлын шавар, хуруун хүүхэлдэй, тоглоом, хуруун хүүхэлдэй эсвэл үлгэр ярьж өгөөч гэж гуйна, тэгэхдээ эдгээр хэрэглэгдэхүүнээр юу бүтээх, ямар үлгэр ярих талаар тодорхой зааварчлахгүй. Харин юу сонгож бүтээж байгаа, юуны тухай ярьж байгаагаар нь юу бодож мэдэрч байгааг нь анзаарч мэдэж болно. Энэ арга ярилцлага юм уу, уулзалтын эхэнд хүүхэд өөрийнхөөрөө чөлөөтэй байж, бүтээлч хөгжилтэй байх бололцоо олгодог учраас хүүхэдтэй харилцаа тогтоох үр дүнтэй аргуудын нэг болдог.

Шууд арга – Шууд арга нь хүүхдийг урлаг, бүтээлч зүйл хийхийг сэдэвчлэн заадаг. Жишээлбэл “аз жаргалтай дурсамж”-аа зурах, эсвэл “гэрт нь хэн амьдардаг”-ийг дүрсэлж үзүүлэхийг хүсэх зэрэг нь шууд аргын жишээнүүд болно. Эдгээр арга ярилцлагын явцад хүүхдийн амьдралын тодорхой хэсгийн талаар мэдээлэл цуглуулахад маш дөхөмтэй байдаг.

Хүүхдийг илүү сайн ойлгоход туслах шууд хэлбэрийн урлагийн болон тоглоомын аргуудын жишээнээс дурдвал:

- **Хүүхдийг гэр бүлээ (гэрт нь амьдарч байгаа хүмүүс) зураарай гэж хүсэх.** Хүүхэд хэн хэнтэйгээ амьдардгийг мэдэх маш үр дүнтэй арга. Зургаа зурсных нь дараа зургаар дамжуулан гэр бүлийнх нь талаар тодруулж асууж болно, хэн нь хүүхэдтэй хамгийн дотно вэ? Хэнээс нь айдаг вэ? Өдрийн турш гэрийнхэн нь юу хийцгээдэг вэ? гэх мэтчилэн.

Зураг 5. Турк хүүхдийн хүчирхийлэлд өртөхөөс өмнөх үйл явдлын тухай зурсан зураг



Эх сурвалж: Adrants

- **Хүүхдийг өдөр тутамдаа хийдэг зүйлсээ зурахыг хүсэх.** Энэ бол хүүхдийн нэг өдөр хэрхэн өнгөрдөг талаар мэдэж авах үр дүнтэй арга юм. Сургуульд явдаг уу, явдаггүй юу? Хэнтэй хамт байдаг вэ? Хүүхэд зарим найзаа эсвэл үйл явдлыг онцолж байна уу? гэх мэтчилэн.

Зураг 6. Аюулгүйн тойргоо зурсан жишээ



- **Аюулгүйн тойргоо зурахыг хүсэх.** Эхэлж тойрог зураад тойрог дотор өөрийг нь аюулгүй, амар тайван санагдуулдаг зүйлсийг зурна. Аюулгүй байдалд юуг онцолж байгааг нь харах шалгарсан арга. Энэ аргыг ахиулаад цааш нь тойргийн гадна буюу түүнийг айлгадаг зүйлсийг (тойрог зураас нь аюулгүйн хил хязгаарыг бэлгэдэж байгаа гэж үзээд) зуруулж болно. Эндээс хүүхэд хэнийг, юуг эрсдэл гэж хүлээж авч байгаа талаар нэмэлт мэдээлэл гарч ирнэ.

- **Үлгэр ярихдаа хүүхэлдэй ашиглах.** Хүүхэлдэйг ашиглаад хүүхэд биеийнх нь аль хэсэгт хүрснийг үзүүлдэг. Жишээлбэл: хүүхдээс биеийнх нь аль хэсэгт хүрсэн, хаана нь өвдсөнийг хүүхэлдэйн дээр үзүүлээрэй гэж хэлж болно. Ингэхдээ чиглүүлсэн асуулт буюу биеийн тодорхой хэсгүүдийг заагаад “энд хүрсэн үү?” гэж асууж болохгүй. Ийм чиглүүлсэн асуултад хүүхэд харилцаж байгаа хүндээ (энэ тохиолдолд та) тал засахын тулд бодит байдал дээр буюу үнэндээ “үгүй” гэж хариулахаар байсан ч зөвшөөрөөд “тийм” гэж хариулах талтай.

- **Нэг хэлээр ойлголцохын тулд хүүхэлдэй ашиглах.** Биеийн хэсгүүдийг нэрлэсэн нэг утгаар ойлгож харилцахад зураг, хүүхэлдэй ашиглах үр дүнтэй. Арай том хүүхдүүдтэй

харьцуулахад бага насны хүүхдүүд биеийн тодорхой нэг хэсэг, нэг төрлийн бэлгийн сэдэлтэй үйлдлийг олон үгээр давхар илэрхийлж ярих хандлагатай байдаг. Мөн бага насны хүүхдүүд нэг үг, нэг хэлцээр биеийн өөр өөр хэсгийг, өөр өөр бэлгийн сэдэлтэй үйлдлийг илэрхийлэх нь бий. Тиймээс хүүхдийн ашиглаж байгаа үг, хэлц үгийг хүүхэд яг ямар утгаар хэрэглэж байгааг нь тодруулах хэрэгтэй болж байна.

Харилцааны явцад тулгардаг бэрхшээлүүд ба шийдэх аргууд

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй харилцах явцад янз бүрийн бэрхшээлтэй тулгарах нь элбэг. Энэ хэсэгт харилцаанд нийтлэг тохиолддог зарим бэрхшээл, сорилт түүнийг хэрхэн шийдэж болох тухай санааг нэгтгэсэн байна.

Хүүхэд ярихаас татгалзах, ярихгүй байгаа хүүхэд: Заримдаа хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухайгаа ярихаас цааргалдаг. Ярихгүй байгаа хүүхдийг “ярь” гэж тулгаж болохгүй. Харин тэвчээртэй байж, хүчирхийллийн талаар яримаар санагдах хүртэл нь тав тухтай орчин, нөхцөлийг бүрдүүлэхийг хичээх хэрэгтэй. Мөн асран хамгаалагч, эцэг эх, итгэлт хүнээс нь хүүхдэд эрүүл мэнд, аюулгүй байдлын талаас яаралтай тусламж хэрэгтэй байгаа эсэхийг тодруулах нь зүйтэй. Үүний дээр хүүхдийн ойр тойрны насанд хүрсэн хүмүүстэй хамтран тухайн нөхцөл байдлыг ойлгоход нь тус болох мэдээллийг цуглуулахад нь туслаарай. Хүүхэд ярихаас татгалзах ямар шалтгаан байж болзошгүйг нягт ажиглаарай. Таны наснаас ч юм уу, хүйсээс эсвэл ямар нэг зүйлээс тань шалтгаалан хүүхдэд тантай байхад тавгүй санагдаж болно. Хэрэв тийм бол та хүүхэдтэй ажиллаж болох өөр хүнд шилжүүлэх хэрэгтэй. Хүүхэд танд итгэхгүй байгаа нь таны буруу биш. Тиймээс хүүхдэд туслах өөр ямар аргууд байж болохыг эрэлхийлээрэй. Жишээ нь: гэр бүлийнхэнтэй нь ярилцах гэх мэт. Дараах хүчин зүйлсийг бодолцож үзээрэй:

- Өрөөнд байгаа өөр хэн нэгнээс болоод хүүхэд ярихыг хүсэхгүй байна уу?
- Тантай хоёулхнаа үлдэхдээ ярихаа больж байна уу? Тийм бол энэ тохиолдолд таньдаг итгэдэг хүнгүйгээр ярихаас айж байна гэсэн үг.
- Ярилцаж буй орчин аюултай, нууцаа ярьж болохооргүй мэдрэмж төрүүлж байгаа юм биш биз? Эсвэл танаас бишүүрхэж байгаа юм болов уу?

Хүүхэд ярихгүй байхад олон хүчин зүйл нөлөөлж байж болно, юу болох бол гэхээс айх айдас, ичгүүр ч бас үүний нэг нь. Тийм айдастай байх вий гэдгийг сайтар нягтлаад, зохих ёсоор тусална гэдгийг магадалж ойлгуулаарай. Хэрэв хүүхэд хүчирхийллийн талаар огт ярихгүй байвал асран хамгаалагчид нь үйлчилгээний талаар хүүхдэд тодорхой мэдээлэл өгч хамтран ажиллах нь чухал.

Хүүхэд бэлгийн хүчирхийллийг үгүйсгэх: Хүүхэд бэлгийн хүчирхийллийн талаар, ялангуяа бага насны хүүхдийн тохиолдлыг хүүхэд өөрөө биш өөр хүн туслалцаа хүсэж мэргэжлийн байгууллагад ханддаг. Зарим тохиолдолд хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртөж байна гэж сэжиглэсэн эсвэл гэрчилсэн насанд хүрсэн хүн энэ тухай хүүхдээс зөвшөөрөл авалгүй, мэдэгдэлгүйгээр мэдээлэх тохиолдол гардаг. Бэлгийн хүчирхийллийн талаар хүүхэд өөрөө биш өөр хүн мэдээлснээр хүүхэд эхэн үед “хүчирхийлэл болоогүй” гэж үгүйсгэх магадлалтай. Тиймээс хүүхдийн эхэлж хэлсэн өгүүлбэрийг нотлох юм уу, үгүйсгэх гэж оролдох хэрэггүй. Хүчирхийллийг үгүйсгэж байгаа шалтгаан байгаа гэсэн үг юм. Жишээлбэл гадуурхагдах, буруутгагдах вий гэх айдас, ичгүүрийг мэдрэх эсвэл энэ тухай хэллээ гээд өс хонзон санах вий гэх айдас гэх мэт. Нөхцөл байдлыг илүү сайн ойлгохын тулд хүүхдийг асран хамгаалагчдаас тусад нь мэдээлэл цуглуулах хэрэгтэй. Хэрвээ бэлгийн хүчирхийллийг үгүйсгээд байгаа хүүхэдтэй ажиллаж байгаа бол дараах аргуудыг ашиглаарай:

- **Төвийг сахиарай:** Хүүхдийн хэлж байгааг батлах эсвэл үгүйсгэх хэрэггүй. Та үнэн зөвийг шүүх гэж биш харин сонсож, ойлгож, туслахын тулд л байгаа гэдгээ хүүхдэд ойлгуулахыг хичээгээрэй.
- **Баримт цуглуулаарай:** Хүүхэд болон хүүхдийг танд хүргэж ирсэн буюу мэдээлсэн хүнтэй тус тусад нь ярилцаарай. Болж байгаа зүйлийг бүхэлд нь харахын тулд лавлан асуугаарай. Жишээлбэл, хүчирхийлэл үйлдсэн гэж үзэж байгаа хүн, хүүхэд хоёр хоорондоо ямар харилцаатай вэ? Хүүхдийн хүчирхийлэл байна гэж мэдээлсэн хүн ба хүүхэд хоорондоо ямар харилцаатай вэ? гэх мэт.
- **Тэвчээртэй байгаарай:** Хүүхэд ямар нэгэн нэр, хоч авахаас айх эсвэл ичээд ч юм уу бэлгийн хүчирхийллийн талаар яримааргүй эсвэл ярьж чадахгүй байж болно. Энэ үед яриулах гэж хүчлэхгүй, хүүхдийг ойлгон дэмжиж, хүүхэдтэй ямар үг хэллэг ашиглаж, юуг хэлж чадахаар байгаа тэр хэмжээнд нь харилцан ярилцаарай.

Хохирогч/даван туулагч хүүхдийн нас, сэтгэхүй, биеийн өсөлт хөгжлийн онцлогийг харгалзан ярилцлага хийх

Бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхдүүдтэй ярилцахдаа хэд хэдэн хүчин зүйлсийг харгалзан үзэх ёстой бөгөөд тэдгээрийн нэг нь хүүхдийн нас, өсөлт хөгжлийн үе шат юм. Хүүхдийн наснаас гадна өсөлт хөгжилд нь нөлөөлдөг хүчин зүйлс бий. Хүрээлэн буй орчин, боловсрол, соёл, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, нийгмийн болон гэр бүлийн харилцан хамаарал гэх мэт нь бүгд чухал нөлөөтэй. Хүүхэдтэй тогтоосон харилцаандаа үндэслэн хүчирхийллийн талаар ярилцах хугацааг оновчтой тодорхойлох хэрэгтэй. Ерөнхийдөө наснаас нь хамааруулан бэлгийн хүчирхийллийн талаар ярилцахад зохистой хугацааг дараах байдлаар оноодог. Үүнд:

- 9 болон түүнээс доош насны хүүхэдтэй 30 минут
- 10-14 насны хүүхэдтэй 45 минут
- 15-18 насны хүүхэдтэй 60 минут

Хүүхдийн нас, өсөлт хөгжлийн үе шатнаас нь хамааруулан хэрхэн ярилцлага хийх тухай дор нэгтгэв.

- **Нялх балчир хүүхэд (0-5 нас):** Энэ насны хүүхдүүдээс бэлгийн хүчирхийллийн талаар шууд асуудаггүй. Үг, хэл ярианы чадавх нь хязгаарлагдмалаас гадна хүчирхийллийн талаар ярих магадлал маш бага. Энэ насныхны хувьд хүүхдийн тухай, болзошгүй хүчирхийллийн талаар эцэг эх, асран хамгаалагчдаас (хүчирхийлэлд сэжиглэгдээгүй) гол мэдээллийг авах боломжтой. Мөн хүүхэдтэй ойр харилцдаг бусад хүмүүс, тэр дундаа хүүхдийг харж асарч байсан хүмүүстэй ярилцаж үзэх хэрэгтэй.
- **Бага насны хүүхэд (6-9 нас):** Энэ насны хүүхэдтэй үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн шууд ярилцаж болох боловч хүчирхийллийн талаарх мэдээллийг боломжтой бол хүүхдийн эргэн тойронд байгаа өөр найдвартай эх сурвалжаас цуглуулахыг зөвлөдөг. Өдий насны хүүхдүүд ерөнхийлсөн асуултад хариулахдаа сайнгүй байдаг. Тийм учраас “Би санахгүй байна” эсвэл “Мэдэхгүй” гэсэн үгс олон сонсогдоно. Эсвэл “Тэр хүн муу зүйл хийсэн” гэх мэтчилэн бүдэг бадаг хариулт хэлээд цааш тодруулж ярихгүй байх нь элбэг. Хэрэв хүүхэд хүсэж байвал ярилцлагын үеэр хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч ч юм уу итгэлтэй хүнийг байлцуулж болно (тухайн хүн нь хүчирхийллийн сэжигтэн байх ёсгүй). Энэ насны хүүхэдтэй үгэн болон урлагт суурилсан харилцааны аргуудыг хослуулан ярилцах нь илүү үр дүнтэй байдаг. Ийнхүү ярилцахдаа тодорхой оноосон үг хэллэг хэрэглэх хэрэгтэйгээ, мөн хийсвэр ойлголт (Жишээ нь: хайр, шударга ёс)-ын талаар ярихаас зайлсхийх ёстойгоо мартуузай.

- **Өсвөр насныхан (10-18 нас):** Энэ насны хүүхэдтэй үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн шууд ярилцаж болно. Бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулахдаа нээлттэй асуулт тохиромжтой. Хүүхэд хүсвэл эцэг эх, асран хамгаалагч юм уу өөр бусад хүүхдийн итгэлийг хүлээсэн хүнийг ярилцлагын үеэр байлцуулж болно (тухайн хүн нь хүчирхийллийн сэжигтэн биш байх хэрэгтэй). Хэдийгээр өсвөр насныхан аливаа зүйлийг шүүн тунгаах чадвартай хэдий ч тэднийг хараахан нас биед хүрээгүй өсөж яваа гэдгийг бүү мартаарай.
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсвэл өртсөн байж болзошгүй тохиолдолд үгэн харилцаа буюу ярилцлагын арга төдийлөн үр дүнтэй байж чадахгүй. Энэ тохиолдолд эрүүл мэнд, нийгэм-сэтгэл зүйн тохирох өөр мэргэжилтэнд шилжүүлэх нь зүйтэй бөгөөд тэд дараах аргуудыг ашиглахад тохиромжтой байдаг. Үүнд:
 - Хүүхдийн асран хамгаалагч (хүүхдийн дотно итгэлтэй харилцаж байгаа тэр хүн)-ийг олж, мэдээлэл цуглуулах
 - Таныг өөрт нь анхаарч дэмжиж байгааг анзаарч, тантай байхдаа дасахад нь тусалж үгэн бус харилцааны аргыг ашиглах
 - Хүүхэлдэй, тоглоом, зураг бүтээлч хэрэгслээр дамжуулан хүүхэд чөлөөтэй харилцах бололцоог нь олгоорой.

2.2.3. Хохирогч/даван туулагч хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдыг дэмжих арга зүй

Сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалыг ашигладаг байгууллага, мэргэжилтэн, ажилтнууд нь сэтгэцийн гэмтэл болон түүнээс үүдэлтэй хүүхдийн зан үйл, хөгжилд нөлөөлөх сөрөг нөлөөллийн талаар сайн ойлголттой байх нь чухал байдаг.

Байгууллага болон мэргэжилтний хохирогч/даван туулагч хүүхдэд үзүүлдэг аль ч төрлийн үйлчилгээ нь сэтгэцийн гэмтэлд суурилсан байх ёстой. Эцэг эхчүүд болон асран хамгаалагчдад сэтгэцийн гэмтэл нь хүүхдэд ямар нөлөө үзүүлдэг талаар зохих сэтгэлзүйн боловсролыг олгосноор сэтгэцийн гэмтлийн дараах илаарьшихад туслах нэг чухал арга зам болно. Хэрвээ тухайн хүүхэд сургуулийн насны бол, энэ сэтгэлзүйн боловсролыг багш нарт бас олгоно. Шаардлагатай тохиолдолд эцэг эхчүүд, асран хамгаалагчдыг сэтгэцийн гэмтэлд суурилсан сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал үзүүлдэг өөр бусад байгууллагатай холбон зуучилж болно (ялангуяа ураг төрлийн хүчин болон үе дамжсан сэтгэцийн гэмтэл бүхий тохиолдолд).

Байгууллага, мэргэжилтэн нь эцэг эхчүүд, асран хамгаалагчтай шууд ажиллаж байгаа эсэхээс үл хамааран, сэтгэцийн гэмтэлд өртсөн хүүхдүүдтэйгээ харилцах харилцаа холбоог сайжруулахыг зорьж, эцэг эхчүүд, асран хамгаалагчдыг дараах зарчим баримтлахыг урамшуулж, чиглүүлэх шаардлагатай (Др.Брюс Перригийн Сэтгэцийн гэмтэлд өртсөн Хүүхдүүдтэй Ажиллах Зарчмууд⁴):

Тухайн сэтгэцийн гэмтэлд өртсөн үйл явдлын талаар ярихаас зайлсхийхгүй байх: Насанд хүргэгчид хүүхдүүдэд тэдний сэтгэцийн гэмтлийн талаар сануулахгүй, бодогдуулахгүй байх нь хүүхдийн эрх ашигт нийцнэ гэж ихэвчлэн эндүүрч боддог. Энэ нь үнэн биш юм. Хэрвээ хүүхэд эцэг эх, асран хамгаалагч нь тэдний сэтгэцийн гэмтлийн талаар ярих дургүй, айж эмээдэг гэж ойлговол, өөрт тулгарсан сэтгэцийн гэмтлийн талаар ярихаас зайлсхийж, бүрэн хаалттай болж болзошгүй бөгөөд энэ нь тэдний эдгэрч илаарьших үйл явцад сөргөөр нөлөөлж болно. Хэдийгээр тухайн гэмтэл учирсан үйл явдлын талаар эцэг эхчүүд, асран хамгаалагчид

4 Перри, Б (n.d.) Гэмтэл авсан хүүхдүүдтэй ажиллах зарчмууд. http://teacher.scholastic.com/professional/bruceperry/working_children.htm

гэнэт эсвэл ямар ч шалтгаангүйгээр ярихгүй байх нь чухал боловч хэрвээ хүүхэд энэ талаар ярьж эхэлбэл яриаг үргэлжлүүлж, ярих тохиромжтой цаг хугацаа, орон зайг нь бүрдүүлж өгөх шаардлагатай. Эцэг эхчүүд, асран хамгаалагчид хүүхдийнхээ асуултыг сонсож, анхааран халамжилж, дэмжлэг үзүүлж, хариулж байх шаардлагатай (боломжтой бол). Хүүхэд өөрийгөө сонсож, халамжлуулах энэ орон зай болон аюулгүй орчныг бүрдүүлснээр эцэг эхчүүд, асран хамгаалагчид илаарьшихыг дэмжиж, тусалж байгаа хэрэг юм.

Өдөр тутмын амьдралын хэмнэл нь жигд, таамаглаж болохуйц, тогтмол байх: Сэтгэцийн гэмтэл авсан хүүхэд аюулгүй орчинд, тусалж дэмжлэг авч болно гэдгийг мэдэрч байх нь тун чухал. Хэрвээ эцэг эх, асран хамгаалагч нь маш их санаа зовнилтой, тогтворгүй байвал сэтгэцийн гэмтэл авсан хүүхдүүд илүү их стресст ордог. Эцэг эхчүүд, асран хамгаалагчид аль болох тайван байж, хүүхдэд ээлтэй, тайван, тогтвортой орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн амьдралын өдөр тутмын хэмнэлийг ойлгуулж, хэвийн үргэлжлүүлснээр гэр бүлдээ тайван орчныг бүрдүүлж болно (жишээ нь хэдэн цагаас босох/унтах, хэзээ хоол идэх, тоглох, хичээлээ хийх гэх мэт). Хэрвээ тогтмол хийдэг үйлдэл гэнэтийн өөрчлөлт орвол (жишээ нь хичээлийн дараа эмчид үзүүлэх, хамаатны хүн хоол унд идэхээр зочлон ирэх) энэ өөрчлөлтийн учир шалтгааныг аль болох эрт, тайвнаар тайлбарлаж өгнө. Хэрвээ эцэг эх, асран хамгаалагч олон ажилд дарагдсан, уур уцаартай, эсвэл санаа нь зовж уймарсан бол өөрт төрч буй эдгээр мэдрэмж нь болж өнгөрсөн хүчирхийллээс эсхүл өөрөөс нь болоогүй, хүн бүрд тохиолддог хэвийн зүйл бөгөөд мэдрэмж, сэтгэл хөдлөл ирсэн шигээ бас алга болно гэдгийг хүүхдэд тайвширсан үедээ тайлбарлаж өгөх хэрэгтэй.

Урам өгсөн, тайвшруулж дэмжсэн орчныг бүрдүүлэх: Тусалж дэмжсэн, итгэлцлийн харилцааг бий болгосноор сэтгэцийн гэмтэл авсан хүүхдүүдэд хамгаалагдсан, аюулгүй байдал нь бүрэн хангагдсан мэдрэмжийг төрүүлнэ. Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд хайр, халамж, дотно харилцааг аюул, эргэлзээ будилаан, өвдөлт зовуурьтай холбож ойлгож болох талаар эцэг эхчүүд, асран хамгаалагчид мэдэж байх шаардлагатай. Бие махбодын тав тухтай байдал, дотно харилцаа нь сэтгэцийн гэмтэл авсны дараах хүүхдийн хөгжилд хамгийн ач холбогдолтой хэвээр байдаг бөгөөд тухайн хүүхдийн нөхцөлд тохируулан тав тух, дотно харилцааг хэвээр үргэлжлүүлээрэй. Жишээ нь, хүүхэд өөрөө хүсэж, санаачилсан бол зохистой нөхцөлд хүүхэд эцэг эх, асран хамгаалагчдаа хүрэлцэж, тэвэрч, үнсэж, барих тохиолдолд мөн адилхан хариу үйлдэл үзүүлэх хэрэгтэй.

Зан үйл, хүлээлт, сахилга батын тухай ярилцах: Сэтгэцийн гэмтэл авсан хүүхдүүдэд зан үйлийн өөрчлөлт гарах нь нийтлэг байдаг. Эдгээрт гэртээ, эсвэл олон нийтийн газарт, сургууль дээрээ гаргаж буй нэлээн хэцүү зан үйлүүд багтан орж болно. Эцэг эхчүүд, асран хамгаалагчид энэ талаар байгууллага, мэргэжилтэнд мэдэгдэж, ил тод ярилцахыг хичээгээрэй. Энэ ярилцлагаар эцэг эхчүүд, асран хамгаалагчид гэр орондоо тодорхой дүрэм журмыг сахиулахад чиглэж, дэмжсэн байх ёстой. Хүүхдийг өөр асран хамгаалагчид өгөх үед (эсвэл анхны эцэг эх, асран хамгаалагчийн гэрээс авч явах үед) мэргэжилтнүүд нь шинэ асран хамгаалагчийг тухайн хүүхдийн анхны гэр бүлээс ялгаатай байж болох өөрийн хүлээлт болон сахилгын арга барилын талаар ярилцахыг нь дэмжээрэй. Эцэг эхчүүд, асран хамгаалагчид бүгдээрээ хохирогч/даван туулагч хүүхэдтэй нэгэн жигд харилцаж, хариу арга хэмжээ авч байгаа эсэхдээ анхаарч байгаарай. Харин бие махбодын шийтгэлээс үргэлж зайлсхийж байгаарай.

Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээг үзүүлэхийн тулд мэргэжилтнүүд, ажилтнууд тасралтгүй суралцах, чадавхжих

Тогтмол суралцах: Сэтгэцийн гэмтлийн талаар болон хохирогчид ээлтэй үйлчилгээний сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг авч, арга зүйд тогтмол суралцаж, хөгжинө.

Сэтгэцийн дам гэмтлийг зохицуулах:

Хүчирхийллийн хохирогч/даван туулагчид үйлчилгээ үзүүлэх нь “хямралын ажил, үйлчилгээ” тул ажилтнуудыг сэтгэцийн дам гэмтэлд (vicarious trauma) орохоос урьдчилан сэргийлэх, өөрийгөө халамжлах (selfcare) арга хэмжээг өөртөө болон байгууллага, удирдлагын зүгээс онцгойлон анхаарч төлөвлөж, мэргэжилтэн, ажилтан нь тогтмол хэрэгжүүлж, зохицуулна.

Стрессээ зохицуулах: Мэргэжилтнүүд, ажилтнууд нь өөрийн хувийн сэтгэл зүйн асуудлууд, стрессийг зохицуулж, хувийн асуудлаа ажлын харилцаандаа оруулахаас урьдчилан сэргийлнэ.

Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх:

Нэг мэргэжилтэнд ногдох кейсийн тоог тэнцвэржүүлж, супервайзор нь мэргэжлийн арга зүй, удирдлагаар тогтмол, чанартай хангаж ажлаас халшрах хам шинжид (burn-out) өртөхөөс сэргийлнэ.

Хувцаслалтыг зохицуулах: Цагдаа, эмнэлгийн байгууллагын харьяа, дэргэд ажиллаж буй түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнууд хохирогч/даван туулагч хүүхэдтэй харилцахдаа дүрэмт хувцаснаас аль болох татгалзаж, энгийн хувцаслаж харилцаарай.

Хамт олны эрүүл харилцаа: Байгууллагын ажилтнууд бие биедээ хүндэтгэлтэй хандаж, эрүүл харилцаатай байгаарай. Үйлчлүүлэгчдийн дэргэд ямар нэг асуудлаар үйл ойлголцох, зөрчилдөөн үүсгэх нь үйлчлүүлэгчдэд таагүй сэтгэгдэл төрүүлэх, ажилтанд болон үйлчилгээнд хандах сөрөг хандлагыг бий болгох, үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг санаарай.

Харилцааны хил хязгаар: Мэргэжилтэн, ажилтан нь холбогдох хуулийн хүрээнд, ажлын байрны дүрэм журам, мэргэжлийн ёс зүйг баримталж хохирогч/даван туулагч хүүхэдтэй харилцахдаа зохистой хил хязгаарыг баримтлан, хувийн харилцаанд орохгүй байна.

Бэлгийн хүчирхийллийн улмаас хохирогч/даван туулагчид бие махбод, сэтгэл санаа, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал үүсэх нь хамгийн том бодит хохирол бөгөөд үүний зэрэгцээ эмчилгээ, оношилгоо, өмгөөлөгчийн зардал, бусад эд материалын хохирол зэрэг эдийн засгийн хохирол хохирогч/даван туулагч тэдний гэр бүлд учирч байна.

“Хохирлын үндэсний тогтолцоо” тодорхой төрлийн гэмт хэргийн хохирол, хор уршгийн нөхөн төлүүлэлт судалгаа, ННФ, Монголын криминологичдын холбоо, 2020 он

Хүүхдэд тогтолцооноос үүдэлтэй сэтгэцийн гэмтэл учруулж болзошгүй үйлдэлд дараах зүйлс орно. Үүнд:

- Хүүхдийн буруу зан үйлийн шалтгаан болон сэтгэцийн гэмтэлд өртсөн түүхийг судлахгүй, тодорхойлохгүй орхих;
- Хүүхдийн сэтгэцийн гэмтлийн шалтгаан, түүхийг тогтоосон ч хүүхдэд үнэлгээ хийхгүй, үйлчилгээ үзүүлэхгүй байх;
- Хүүхдийн бие махбод болон сэтгэл зүйн аюулгүй байдлыг хангахгүй байх;

Үйлчилгээний байрлал тогтвортой биш байх (олон тийш нь явуулах, жишээлбэл эмнэлэгт үзүүлэхээр өөр эмнэлэг рүү дахин дахин явуулах гэх мэт), үзүүлэх үйлчилгээ нь тодорхой биш байх, хүүхдэд тайлбарлаж өгөхгүйгээр гэнэт үйлчилгээнд хамруулах (гэнэт огт танихгүй орчинд хамгаалах байранд ганцаар нь байрлуулах гэх мэт) нь хүүхдийн сэтгэцийн гэмтлийн стрессийг улам нэмэгдүүлдэг.

2.3

СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛД СУУРИЛСАН ХОХИРОГЧ/ДАВАН ТУУЛАГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОГТОЛЦОО, ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕХАНИЗМ БА САЙН ТУРШЛАГА

Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагчдад ээлтэй үйлчилгээний тогтолцоо нь өргөн хүрээний ойлголт бөгөөд хууль, бодлого, удирдлага, хяналт болон хэрэгжүүлэх буюу үйлчилгээ үзүүлэх гэсэн бүрэлдэхүүнтэй. Энэхүү гарын авлага нь хохирогч/даван туулагчид үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтнүүдэд зориулагдсан тул тогтолцоог бүхлээр нь бус хохирогч/даван туулагчид үйлчилгээ үзүүлэх тогтолцооны асуудлыг тусгасан болно.

Үйлчилгээний тогтолцоо нь сэтгэцийн гэмтлийн талаар мэддэггүй, ойлгодоггүй, ач холбогдол өгдөггүйгээс хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг улам дордуулж, дахин гэмтээж, давхар хохироож байдаг. Нийт хүүхдийн 71-ээс доошгүй хувь нь амьдралдаа дор хаяж нэг удаа, 17 нас хүртлээ олон удаа, асрамж халамжийн байгууллагад амьдарч байгаа хүүхдийн 85% нь сэтгэцийн гэмтэлд өртсөн байна. Сэтгэцийн гэмтлийг илаарьшуулахгүй орхивол хувь хүн, гэр бүл, нийгэмд илүү их хор хөнөөл учруулах болно.

Сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний тогтолцоо нь дараах шинж чанартай байдаг. Үүнд:

1. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг зохицуулах, үйлчлүүлэгч төвтэй байх ба “насан туршийн” гэсэн хандлагатай байна. Сэтгэцийн гэмтэл нь хүний амьдралын бүхий л талбарт нөлөөлж байдаг тул уялдаа холбоо нэн чухал байдаг. Байгууллагууд гэдэгт эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсрол, хууль эрхзүйн гэх мэт бүхий л үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд багтана.
2. Бодлогын баримт бичгүүд, түүнийг дагалдах журмууд бүгд сэтгэцийн гэмтэлд суурилсан буюу хохирогч/даван туулагчдад ээлтэй байхыг тусгасан байна.
3. Үйлчилгээний чанарыг хянах механизмыг бий болгож сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний зарчим мөрдөгдөж байгаа эсэхийг шалган үнэлнэ.
4. Бүхий л баримт бичгүүд төрөл бүрийн бүлгийн хүмүүсийн хэрэгцээ шаардлагаас гадна нас, хүйс, жендэр, бэлгийн чиг баримжаа, нийгэм-эдийн засгийн гарал үүсэл/байдал, амьдарч буй байршилд хүндэтгэлтэй хандана.
5. Үйлчлүүлэгчийн идэвхтэй оролцоог төлөвлөлт, хэрэгжилтэд ямагт хангаснаар нээлттэй, ил тод тогтолцоо бий болж үйлчилгээ сайжирч үйлчлүүлэгчийн даван туулах, илаарьших үйл явц эерэг, эрүүлээр явагдах боломжоор хангагдана. Үйлчлүүлэгчийн идэвхтэй оролцоо нь энэ тогтолцооны чанар, чадамжийн гол зүйл ба бүхий л үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулна.

Зохих ёсны дэмжлэг туслалцаатайгаар хүмүүс сэтгэцийн гэмтлийн үр нөлөөг багасгаж, даван туулж чадна. Сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний тогтолцоо нь дахин гэмтэх, давхар хохирохоос сэргийлж, гэмтлийн үр нөлөөг эрт илрүүлж, илаарьшуулж, үр дүнд хүргэнэ.

Сэтгэцийн гэмтэлд суурилсан тогтолцоо нь хохирогч/даван туулагч хүүхэдтэй холбоотой хүмүүс хамтран ажиллаж, харилцан дэмжихийг шаарддаг. Ингэснээр сэтгэцийн гэмтлийн талаар бүгд мэддэг ойлгодог, ур чадвар, нөөц боломжоо ашигладаг, хамгийн сайн туршлагаа хэрэглэдэг, хамтдаа илаарьшдаг, дахин гэмтээж, хохироодоггүй байна.

Хүүхэд болон тэдний гэр бүлийн бие махбод болон сэтгэл зүйн аюулгүй байдлыг дээд зэргээр хангах. Учирч болзошгүй аюулыг тодорхойлж, хүлээн зөвшөөрч, аюулгүй мэдрэмжийг нэмэгдүүлэх, сэтгэцийн гэмтлийг сэдэрэх хүчин зүйлүүдийг тодорхойлж, хариу арга хэмжээ авна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль болон холбогдох журмуудыг судлах, хэрэгжүүлэхэд анхаарах. (Аюулын зэргийн үнэлгээ, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалаар хэрэгжүүлэх)

Хүүхэд болон гэр бүлд сэтгэцийн гэмтлээс үүдэлтэй үүссэн хэрэгцээг тодорхойлох. Хүүхэд гэр бүлд үүссэн суурь буюу анхдагч хэрэгцээ, нийгэм-сэтгэл зүйн хэрэгцээг тодорхойлох, сэтгэцийн гэмтлийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээг хийж, илрүүлэх. (Нийгмийн халамж, хамгаалал, боловсрол, эрүүл мэнд зэрэг бүхий л байгууллагууд хамтрах ба хэрэгцээг бодитоор үнэлэн илрүүлэх. Нөхцөл байдлын үнэлгээг сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалаар хийх)

Хүүхэд, гэр бүлийн сайн сайхан байдал, дасан зохицох чадварыг дээшлүүлэх. Сэтгэцийн гэмтэлд өртүүлсэн үйл явдал нь гэр бүлийн бүх гишүүдэд ямар нэгэн байдлаар нөлөөлж, гэр бүлийн харилцаа, нөхцөл байдалд сөрөг үр дагаврыг бий болгодог. Тиймээс гэр бүлийн гишүүдийг бие биеэ ойлгож, хүндэтгэж, дэмжсэн эрүүл харилцаатай байхад анхаарна. Ингэснээр гэр бүл хамтын илаарьшил буй болж өнгөрсөн үйл явдлыг бүгдээрээ даван туулах, нөхцөл байдалд гарсан өөрчлөлтүүдэд эрүүлээр дасан зохицох, бие биеэ дэмжих боломж бүрдэнэ.

Хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлэх олон талын байгууллагуудтай хамтран ажиллах. Хүүхэд гэр бүлд үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын түншлэлийг хүчтэй болгон хамтдаа сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээг үзүүлэх. Хохирогч/даван туулагчид үйлчилгээ үзүүлэхээс гадна гэр бүлд бүхэлд нь нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлнэ. Тухайлбал гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө, шаардлагатай тохиолдолд гэр бүлийн гишүүдэд ганцаарчилсан зөвлөгөө, гэр бүлийн харилцааг сайжруулах дэмжих бүлэг, эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ гэх зэрэг үйлчилгээг хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүргэнэ.

Байгууллагын ажилтнуудын сайн сайхан байдал, уянхатан чадварыг нэмэгдүүлэх. Хохирогч/даван туулагчид үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтэн, ажилтнууд нь өдөр тутамдаа аюул, заналхийлэл, хүчирхийллийн үр дагаврыг мэдэрч байдаг. Мэргэжилтнүүд хохирогч даван туулагчийн онцлог байдал, айдас, уур хилэн, холилдсон мэдрэмжийг ойлгон мэдэрч болно. Зарим тохиолдолд гэр бүлийн орчинд, эсвэл хүүхэд насандаа сэтгэцийн гэмтэл авсан мэргэжилтнүүд хохирогч/даван туулагчийн нөхцөлийг өөрийн мэтээр хүндээр мэдрэх эрсдэл өндөртэй байж болно. Хохирогч/даван туулагчидтай тасралтгүйгээр байнга ажиллах нь мэргэжилтнүүдийн сэтгэл санааны болон бие махбодод ихээхэн эрсдэлийг учруулж, эрүүл мэндэд нөлөөлж, үр дүнтэй ажиллах чадварыг бууруулдаг. Тиймээс мэргэжилтнүүдийг сэтгэцийн дам гэмтэлд өртөхөөс сэргийлж, зохицуулж, сайн сайхан, эрүүл мэргэжилтэн байхыг сурталчлах, дэмжих хэрэгтэй. Үүний тулд: Мэргэжилтнүүд нь хувийн амьдрал, ажлын тэнцвэртэй байдлыг хангах, үйлчлүүлэгчтэй хил хязгаартай харилцах, ажлын цагийг тодорхой баримтлах, амралтын цагаараа өөртөө болон гэр бүлдээ анхаарах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ур чадвараа нэмэгдүүлэх, супервишн кейс хэлэлцүүлэг зэрэг мэргэжил арга зүйн дэмжлэгтэй байх нь зүйтэй.

Тохиолдол 12

Сэтгэцийн гэмтэлд суурилагүй, хохирогч/даван туулагчид ээлгүй үйлчилгээний тохиолдол

Ү нь 9 настай, эрэгтэй. Хойд ээжийнхээ төрсөн ахын зүгээс 4 жилийн хугацаанд бэлгийн хүчирхийлэлд өртсөн. 2021 оны 3 дугаар сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас цагдаад дуудлага мэдээлэл өгөх үеэр бэлгийн хүчирхийлэлд өртдөг байсан талаар хүүхэд өөрөө мэдэгдсэн. Хүүхдийг харьяа дүүргийнх нь түр хамгаалах байранд байрлуулсан бөгөөд тухайн дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон ажиллахаар болсон. Ү-г хамгаалах байранд байрлах хугацаанд харьяа төрийн байгууллага гэр бүлтэй нь ажиллаагүй, хүүхдийг цаашид гэр бүлд нь эргэн нэгтгэх, эсвэл асрамж халамжийн төвд шилжүүлэх эсэх талаар тодорхой арга хэмжээ авахгүй байсаар 9 сар хамгаалах байранд нь байрлуулсан. Энэ хугацаанд хүүхдийн гэр бүлийн харьяалал өөрчлөгдсөний улмаас өөр дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс хариуцахаар болсон гэх шалтгаанаар хууль ёсны төлөөлөгч солигдож, дараагийн дүүргээс томилогдохдоо хоёр сар гаруй хугацаа өнгөрсөн. Гэвч шинээр томилогдсон хууль ёсны төлөөлөгч нь “их ажилтай, завгүй” гэдэг шалтгаанаар мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцдоггүй байсан. Хүүхдийн өмнө үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь энэхүү бэлгийн хүчирхийллийн Тохиолдол дээр Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хүүхэдтэй холбоотой ямар нэгэн шийдвэр гаргахдаа түүний санаа бодлыг хүндэтгэж үзээгүй, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17.1.4 дүгээр зүйлд заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэхэд хамтран ажиллах үүргээ биелүүлээгүй. Улмаар хүүхэд зөрчигдсөн эрхээ хамгаалуулж, төрийн үйлчилгээг хууль, журмын дагуу авч чадалгүй байсаар байрлаж байсан хамгаалах байрнаас оргож хүчирхийлэлтэй харилцаатай гэр бүлдээ эргэн очсон.

Сэтгэцийн гэмтэлд суурилсан хуулийн байгууллагын үйлчилгээ

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч/даван туулагч хуулийн байгууллагад гомдол гаргасан ч энэ төрлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явц нь хохирогчдод ойлгомжгүй, төвөгтэй, даван туулахад хүндрэлтэй, ихэнхдээ урт хугацаанд үргэлжилдэг учир хохирогч хууль хяналтын байгууллагаас залхах, зугтах явдал гарч байна. Цагдаагийн байгууллага нь хохирогч/даван туулагч хүүхдэд үйлчилгээ үзүүлэхдээ дараах нийтлэг алдааг гаргадаг. Үүнд:

- Оновчтой үг хэллэг, бичилт хийж мэдүүлэг авч чаддаггүй, ажилдаа хайнга хандаж гэрч, хохирогчоос удаа дараа мэдүүлэг авч чирэгдэл үүсгэх;
- Илтэд зөрүүтэй биш, бага зэргийн зөрүүтэй өгсөн мэдүүлэг болон бусад баримтад үг үсгийн алдаа хайх, “тоглолт хийх” буюу хэрэг хянаж, шийдвэрлэх ажиллагаанд санаатайгаар саад учруулах;
- Хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, хамгаалахад хайхрамжгүй ханддаг;
- Хохирогч/даван туулагчийн хууль ёсны төлөөлөгч үүргээ биелүүлж чадах эсэх эсхүл төлөөлөх боломжгүй нөхцөлийн талаар судалдаггүйгээс ялангуяа ураг төрлийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч мэдүүлгээсээ буцах тохиолдол багагүй гарч байгаа нь зарим тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгоход нөлөөлдөг;
- Мөрдөгч, прокурор нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруутай үйлдлийг л тогтоох, нотлоход анхаардаг бөгөөд шүүх хэргийг шийдвэрлэхэд тухайн хэргийн улмаас учирсан хохирлыг шалгасан тогтоосон байдал, хохирлыг барагдуулсан эсэхэд мөн л дүгнэлт хийхгүйгээр хэргийг шийдвэрлэдэг буруу практик тогтсон байна.

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг үйлдсэн этгээдийн үйлдэл, холбогдлыг хөдөлбөргүйгээр баримтаар тогтоох, хэргийг зөв зүйлчлэх, гэмт этгээдэд ял завшуулахгүй байх, зохих ял шийтгэл оногдуулах, хохирогч/даван туулагчийн аюулгүй байдлыг хангах, дахин хохироохгүй байхад анхаарах, хохирогчид учирсан хохирлыг зөв тодорхойлох, хэргийн үл мөр замхрах,

устгах явдлыг гаргахгүй байх зэрэг хуульд заасан олон ажиллагааг шуурхай авч хэрэгжүүлэх шаардлага мөрдөгч, прокурор, өмгөөлөгч, шүүгч нарт зүй ёсоор тавигддаг.

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээ үзүүлэхэд дараах зүйлүүдийг анхаарна. Үүнд:

- Холбогдогч, хохирогч нарыг тусгаарлах, гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг бодитоор хамгаалаарай. Жишээ нь: нэг тээврийн хэрэгслээр хамт зөөвөрлөхгүй, нэг газар, өрөөнд байлгахаас зайлсхийх.
- Сэжигтэн, яллагдагч, хохирогч, гэрч нараас мэдүүлэг авах өдрийг зөрүүлэх, тэдгээрийг уулзуулахгүй байх арга хэмжээ авах.
- Гэрч, хохирогчийн эрүүл мэнд, аюулгүй байдал, нэр төр, алдар хүнд, хувь хүний нууцыг хамгаалахад онцгой анхаарч ажиллах, хэрэг шийдвэрлэж дуустал, цаашид хугацаагүй нууцалж хамгаалах үүргийг мөрдөгч, прокурор, шүүгч хүлээнэ.
- Хуулийн байгууллагын мэргэжилтэн, ажилтан нь сэтгэцийн гэмтлийн талаар шинжлэх ухааны анхан шатны мэдлэг, мэдээлэлтэй байж, мэдлэг, чадвараа хөгжүүлж, хохирогч/даван туулагчийн сэтгэл зүйд учирсан эмгэг, өөрчлөлтийг бодитой тодорхойлж, дүгнэлт гаргуулж байх нь хохирогч/даван туулагчийн эрхийг хамгаалах, гэмт халдлагын үлмаас учирсан хохирлыг зөв тогтооход ач холбогдолтой. Хуулийн байгууллагын мэргэжилтэн, ажилтнууд нь хэрэг хянан шийдэх ажиллагааг сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй, хүний эрхэд суурилсан хандлагаар, аливаа дарамтаас ангид явуулах, хохирогчийг бусад үйлчилгээ, дэмжлэгт хамруулах, аюулгүй байдлыг нь хангах, гэмт этгээдэд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой олон асуудал амжилттай шийдвэрлэхэд чиглэсэн мэдлэг, арга зүйг дэлгэрэнгүйгээр ХЭҮТ-өөс 2020 онд боловсруулсан **“Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах арга зүй: хэрэг бүртгэгч, мөрдөгч нарт зориулсан гарын авлага”**-аас авна уу.

Хуулийн байгууллагад сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээг хөгжүүлж буй сайн туршлага

АНУ-ын Төрийн Департаментын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх газрын буцалтгүй тусламжаар Дэлхийн Зөн ОУБ болон Азийн Сан хамтран “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Мөрдөн шалгах газар, Хан-Уул дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 1-р хэлтэст хүүхдэд ээлтэй өрөөг бий болгон тохижуулж, ашиглалтад оруулжээ. Гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхэдтэй ярилцлага хийх, мэдүүлэг авах үед дахин цочролд орохоос сэргийлэх, хүүхдийн сэтгэл санааг амар амгалан, аюулгүй тайван байлгаж, хүүхдэд шаардлагатай тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү өрөөг ашиглах зорилготой. Энэхүү өрөө нь зөвхөн хүүхдэд зориулан ашиглагдах ба тоглоом, тоног төхөөрөмж, өнгө дизайн бүхий тайван, аюулгүй орчныг бүрдүүлсэн, хүүхдээс мэдүүлэг авах үеийн баримтжуулалтыг хийх боломжтой тул болсон үйл явдлыг олон дахин яриулахгүй, хэрэгт холбогдогчтой тааралдуулахгүй байхаар зохицуулсан тул аюулгүй байдал алдагдахгүй зэрэг сэтгэцийн гэмтэлд суурилсан, дахин гэмтэлд оруулахаас сэргийлсэн давуу талтай юм.

[www.https://worldvision.mn/](https://worldvision.mn/)

ХЭҮТ-ийн мэргэшсэн өмгөөлөгч нар 2015 оноос бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн сэтгэл зүйд учирсан гэмтлийг тогтоолгох асуудлаар мэргэшин ажиллаж байна.

12 настай М нь 2009 оноос 2014 оны 8 дугаар сар хүртэл 5 жилийн хугацаанд хойд эцгийнхээ зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртөж улмаар сэтгэл зүйн хүнд дарамтад орсон, өөртөө итгэх итгэлгүй, амиа хорлох оролдлогыг олон удаа хийж байсан. Иймд тухайн үйлчлүүлэгчийг мэргэжлийн сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулж, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч нартай хамтран үйлчилгээ үзүүлсэн.

Тухайн үйлчлүүлэгчид гаргасан сэтгэцийн шинжээчийн дүгнэлтэд “хохирогч М нь сэтгэл зүйн гэмтлийн шалтгаант айдас, түгшүүртэй, цаашид сэтгэцийн эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх боломжтой байна” гэсэн бөгөөд энэ нь ХЭҮТ-д сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн сэтгэл зүйчийн үйл явцын тэмдэглэл нь дээрх дүгнэлтийг баталж байсан. Иймд өмгөөлөгч шүүхэд сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргасан. Шүүх хуралдаанд сэтгэцийн шинжилгээ хийхэд оролцсон шинжээч эмчийг гэрчээр оролцуулж, тайлбар авсан.

Шүүх насанд хүрээгүй хохирогч М нь энэ гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хувьд хохирол хүлээсэн болох нь Шүүх сэтгэц эмгэг судлалын сэтгэл зүйн дүгнэлт, сэтгэл зүйчийн үйл явцын тэмдэглэл, шинжээч эмчийн тайлбар, СЭМҮТ-д хэвтэн эмчилгээ хийлгэсэн өвчний түүх гэх мэт нотлох баримтад тулгуурлан сэтгэл санааны хохирол хүлээсэн гэж үзэх үндэслэлтэй байна гэж дүгнэсэн.

“Хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” өмгөөлөгчдөд зориулсан гарын авлагаас, 2020)

Хохирогч/даван туулагчийн сэтгэл зүйд учирсан хор уршгийг нөхөн төлүүлсэн шүүхийн сайн туршлага

Тохиолдол судалгаа: Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг гэмт хэрэгт тооцсон хуулийг хэрэгжүүлэх нь: Доминиканы Бүгд Найрамдах Улс Ерөнхий шүүгчийн ажлын алба, аялал жуулчлалын цагдаа, зоогийн газар зочид буудлын үндэсний холбоо, иргэний нийгмийн байгууллагууд хамтран Доминиканы Бүгд Найрамдах улсын аялал жуулчлалын салбар дахь хүүхдийн бэлгийн мөлжлөгийн эсрэг хуулийг хэрэгжүүлэх чадварыг нэмэгдүүлсэн байна. Хууль сахиулах байгууллагын ажилтнууд, зочид буудлын ажилтнууд, боловсрол эрүүл мэндийн мэргэжилтнүүд, сэтгүүлчид, хүүхэд, эцэг эхчүүд хүүхдийн бэлгийн мөлжлөгийн Тохиолдлыг таньж мэдэх, мэдээлэх сургалтад суусан байна. “Ямар ч шалтаг хэрэггүй” гэх олон нийтийн кампанит ажил нь олон нийтийн дунд мэдлэгийг дээшлүүлж, хүмүүсийг Тохиолдол гарвал мэдээлэхийг уриалсан байна. Тухайн улс нь мөн цахим орчин дахь бэлгийн мөлжлөгийг мөрдөн байцаах сургалт чадавхыг бэхжүүлсэн бөгөөд энэ зорилгоор тусгай хэлтсийг байгуулан ажилласан.

Сэтгэцийн гэмтэлд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ:

Бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагчдад тулгардаг томоохон асуудлуудын нэг нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, тэр дундаа бэлгийн замын халдварт өвчин тусах, жирэмслэх явдал юм. Хохирогч/даван туулагчийг эмнэлгийн үзлэг шинжилгээ, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах нь өвчлөл болон жирэмслэлтийг эрт үед нь илрүүлэх, яаралтай тусламж үйлчилгээг үзүүлэх, эмчлүүлэх, мөн мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх давуу талтай. Харамсалтай нь зарим эмч, эмнэлгийн байгууллагын мэргэжилтнүүдийн зүгээс хохирогчийг буруутгах, нууцлалыг нь задруулах, нэр төрд нь халдах зэргээс сэтгэцийн гэмтэлд суурилагагүй, ээлгүй, мэргэжлийн бус, ёс зүйгүй үйлдлээс болж хохирогч/даван туулагч эрүүл мэндийн үйлчилгээ авахад хүндрэлтэй болж, өвчин нь хүндэрч, даамжрах эрсдэл бий болдог.

Тoхиолдол 13

12 настай, эмэгтэй, ураг төрлийн бэлгийн хүчирхийллийн улмаас жирэмсэлсэн. Харьяа нутаг дэвсгэрийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн төвөөс охины асран хамгаалагчтай зөвшилцсөний дагуу, эмч нарын зөвлөлийн шийдвэрээр үр хөндөлт хийлгэх болсон. Охины хэвтэн эмчлүүлсэн эмнэлгийн байгууллага нь түүнийг насанд хүрсэн эмэгтэйчүүдийн тасагт хэвтүүлэн, үр хөндөлт хийж, эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн.

Хамт хэвтсэн насанд хүрэгчид нь сонжин харж “Ийм багадаа жирэмслээд байхдаа яах вэ, замбараагүй юм” гэхчлэн хоорондоо муулж ярих нь маш ичгэвтэр, тэвчихийн аргагүй байдалд оруулж, хоол ч идэж чадахгүй, босож ч чадахгүй хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөн уйлж хэвтдэг байсан.

Эмнэлгийн байгууллага, мэргэжилтэн, ажилтнуудын гаргадаг нийтлэг алдаа:

- Сэтгэцийн гэмтлийн талаар мэдээлэл, мэдлэг байхгүй, хохирогч/даван туулагчийн сэтгэл зүйн байдлыг ойлгодоггүй, хүндэлдэггүй;
- Бусад үйлчлүүлэгчдийн дунд, урт дараалалд оруулж, удаан хүлээлгэх, нэр, шошго өгч дуудах, ялгаварлан гадуурхах, үл тоох зэрэг харилцаа гаргадаг;
- Хохирогч/даван туулагчийн сэтгэл зүйн бэлэн байдал, тав тух, аюулгүй байдлыг хангахгүйгээр үзлэг, оношилгоо, эмчилгээ хийж, дахин гэмтэлд өртүүлдэг;
- Хохирогч/даван туулагчийн биед шарх сорви, гэмтэл бэртэл илрээгүй, хохирогчийн биеэс үрийн шингэн илрээгүй, онгон хальс цоороогүй тул бэлгийн хүчирхийлэлд өртөөгүй гэх зэргээр шууд дүгнэлт гаргаж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд алдаа гаргуулж, хэргийг хэрэгсэхгүй болгоход нөлөөлдөг.

Хохирогч/даван туулагч хүүхдүүдэд зориулсан анхан шатны үйлчилгээ нь шинж тэмдгийг анхааралтай үнэлж, баримтжуулах, зохих халамж, дараагийн алхмуудыг авах, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэгийг үзүүлэх зэрэг орно. Үйлчилгээ үзүүлэгч нь дам хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, харилцаагаа илүү хүүхдэд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй болгохын тулд дараах алхмуудыг авна.

- Нэн даруй авах ёстой эмнэлгийн анхан шатны тусламжийг тэргүүнд тавих,
- Нийгэм-сэтгэл зүй, эрүүл мэнд, хууль зүй, эмнэлэг болон бусад нарийвчилсан үйлчилгээ авах боломжийг бий болгох,
- Эрүүл мэндийн байгууллага дотор хүүхдийг тасгаас тасаг руу шилжүүлэх хэрэгцээг багасгах,

Баримт цуглуулах болон шүүх эмнэлгийн нотолгоог цуглуулахад тусгай протокол мөрддөг бол эрүүл мэндийн ажилтнууд эдгээр журмыг мөрдөх боломжтой байх үүднээс тэдэнд зохих сургалт, удирдлага болон шаардлагатай материалуудаар хангаж байх нь зүйтэй.

Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээг хөгжүүлж буй сайн туршлага

Бэлгийн хүчирхийлэлд зориулсан тусгайлсан эмнэлгийн Анхан шатны дэмжлэг болон хор холбогдлыг бууруулахын дээр, ДЭМБ нь бэлгийн халдлагад өртсөн гэж үзэж байгаа тохиолдолд тодорхой эмнэлгийн үйлчилгээг үзүүлэхийг зөвлөсөн байна.

Зөвлөмжид дараах интервенцүүдийг хэзээ үзүүлэх, хэрхэн хэрэгжүүлэх талаар зааврыг өөртөө багтаасан байна.

- Бэлгийн харьцааны дараах ДОХ-оос урьдчилан сэргийлэх эмчилгээ
- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидод зориулсан жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, зохицуулах арга зүй
- Эмчлэх боломжтой, вакцинаар урьдчилан сэргийлэх боломжтой бэлгийн замын өвчнүүдээс урьдчилан сэргийлэх

ДЭМБ (2019). INSPIRE гарын авлага: Долоон стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Сэтгэцийн гэмтэлд суурилсан боловсролын байгууллагын үйлчилгээ:

Багш нар нь сургууль дээр сэтгэл зүйн орчныг сайжруулахад чухал үүрэгтэй учраас өөрсдийн мэдлэг, ур чадвар, чадвараа нэмэгдүүлэх шаардлагатай. Захиргааны болон дүүргийн хэмжээний дэмжлэгтэй хослуулсан үр дүнтэй сургалт нь багш нарыг дараах арга зүйг олж авахад тусална.

- Зан үйлийг зохицуулах эерэг хүмүүжлийн арга барилыг хичээл дээрээ ашиглах,
- Өөрсдийн ойлголт таамаг, үнэт зүйл, итгэл үнэмшил болон хүчирхийлэлтэй холбоотой хувийн туршлагыг шинжлэн үзэх,
- Дээрэлхэл, дарамт болон ялгаварлан гадуурхлыг олж тогтоон шийдвэрлэх,
- Хүчирхийллийн тохиолдолд үр дүнтэй хариу үзүүлэх, хамтарсан баг бусад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах,
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд анхан шатны дэмжлэг, холбон зуучлах үйлчилгээг үзүүлэх,
- Сурагчдын оролцоо болон сурлагыг сайжруулах арга зүйг нэмэгдүүлэх интерактив, оролцоон дээр суурилсан арга барилыг хэрэглэх.

Боловсролын байгууллагад сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээг хөгжүүлж буй сайн туршлага

Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургууль нь 2021 оноос эхлэн хүний эрхийн ноцтой зөрчил болох охидын үзлэгийг сургуулийн орчинд зохион байгуулахыг хориглож, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлтэйгөөр эмнэлгийн орчинд, өсвөр үеийн кабинетад мэргэжлийн эмч үзлэг хийж, үзлэгийн болон хувь хүний мэдээллийн нууцлалыг хангаж ажилладаг болсон байна. Мөн мэргэжлийн биологийн багш, эмчээр нөхөн үржихүйн сургалт мэдээллийг сурагч болон эцэг эх, асран хамгаалагчдад тогтмол өгч, бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна.

Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургууль, Илтгэх хуудас, 2021.09.27

НОМ ЗҮЙ

Гадаад хэл дээрх эх сурвалж

- Bessel Van Der Kolk. (2014). *"The Body Keeps The Score"*
- Diane Langberg. *Complex Trauma: Understanding and Treatment*. <https://youtu.be/otxAuHG9hKo>
- Finkelhor, Turner, Ormrod, Hamby,. (2011). *"Children's Exposure to Violence: A Comprehensive National Survey," OJJDP (2009). 6 Miller, et al.*
- Gabor Mate. (2003). *When the body says no*.
<https://store.samhsa.gov/product/SAMHSA-s-Concept-of-Trauma-and-Guidance-for-a-Trauma-Informed-Approach/SMA14-4884>
- J.Herman. (2015). *Trauma and Recovery: The Aftermath of Violence – from Domestic Abuse to Political Terror*.
- Jefferson City: *Missouri Coalition for Community Behavioral Healthcare*
- Mieseler, V., & Myers, C. (2013). *Practical steps to get from trauma aware to trauma informed while creating a healthy, safe, and secure environment for children*.
www.americanbar.org/groups/public_interest/child_law/resources/child_law_practiceonline/
<http://www.nationalcenterdvtraumamh.org/>
- National Child Traumatic Stress Network. (2010). *Caring for Children who have experienced trauma. A workshop for recourse parents*.
- Oppenheim H. (2014). *Die traumatischen neurosen nach den in Nervenlinik der Charité*. Berlin: Hirschwald.
- SAMHSA's concept of trauma. (2014).
- T.Zoellner., A.Maercker. (2006). *Clinical Psychology Review 26*.
- The American Psychiatric Association. (2013). *The Diagnostic and Statistical Manual of Mental Disorders, Fifth Edition (DSM-5)*.
- The National Child Traumatic Stress Network. (2010). *Caring for Children who have experienced trauma. A workshop for recourse parents*.
- Wisconsin Department of Health. <https://www.dhs.wisconsin.gov/>
- World Health Organization. (Jewkes 2002)

Монгол хэл дээрх эх сурвалж

- Баасанбат.С, (2010). *Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний түр удирдамж*.
- Викрам Патель. (2003). *Сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн гарын авлага. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. 138*.

Дүфрэнэ Готьерын Сан. (2020). Хүүхдийн эрх, хамгаалал: практик үйл ажиллагаа, төрийн бус байгууллагуудын санаачилга, сайн туршлага

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага., Эрүүл Мэндийн Яам., Хүчирхийллийн эсрэг үндэсний төв., Монгол Өрх Сэтгэл зүйн хүрээлэн. (2010). Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн “Нэг цэгийн үйлчилгээ”-ний түр удирдамж.

ДЭМБ (2019). *INSPIRE гарын авлага: Долоон стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа*

Монгол Өрх Сэтгэл зүйн хүрээлэн. “Онцгой эрсдэлтэй нөхцөлд хүүхдэд үзүүлэх нийгэм сэтгэлзүйн дэмжлэг”.

Мягмар. О. (2009). *Сэтгэц заслын зөвлөгөөний онол арга зүй*. Улаанбаатар.

Олон Улсын Шилжилт Суурьшлын Байгууллага. (2007). *Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх шууд тусламжийн гарын авлага*.

Оюундарь.Б, (2021). *Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлсэн сэтгэцийн гэмтэлд суурилсан Тохиолдол менежментийн үйлчилгээг судлах нь магистрын зэрэг горилсон судалгааны ажил*.

ХЭҮТ. (2020). *Хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага*.

ХЭҮТ. (2020). *Хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах арга зүй*.

Цагдаагийн Ерөнхий Газар. (2020). *Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын статистик*.

